



Ардчилсан Институт Хүний Эрхийн Газар

# МОНГОЛ УЛС

УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬ  
2024 оны 6 дугаар сарын 28

АИХЭГ-ын Сонгууль ажиглах хорооны  
эцсийн тайлан



Варшав хот  
2024 оны 12 дугаар сарын 13.

## АГУУЛГА

<b>I. ХУРААНГУЙ</b> .....	<b>1</b>
<b>II. ТАНИЛЦУУЛГА, ТАЛАРХАЛ</b> .....	<b>4</b>
<b>III. ҮНДЭСЛЭЛ, УЛС ТӨРИЙН БАЙДАЛ</b> .....	<b>5</b>
<b>IV. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН БА СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО</b> .....	<b>6</b>
<b>V. СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА</b> .....	<b>8</b>
<b>VI. САНАЛ ӨГӨХ ТЕХНОЛОГИ</b> .....	<b>10</b>
<b>VII. СОНГОГЧИЙН БҮРТГЭЛ</b> .....	<b>11</b>
<b>VIII. НАМЫН БОЛОН НЭР ДЭВШИГЧИЙН БҮРТГЭЛ</b> .....	<b>13</b>
<b>IX. СОНГУУЛИЙН КАМПАНИТ АЖИЛ</b> .....	<b>15</b>
<b>X. КАМПАНИТ АЖЛЫН САНХҮҮЖИЛТ</b> .....	<b>18</b>
<b>XI. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ</b> .....	<b>20</b>
A. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ОРЧИН.....	20
B. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН.....	20
C. СОНГУУЛИЙН КАМПАНИТ АЖЛЫГ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛЭЭР ДАМЖУУЛСАН БАЙДАЛ.....	22
<b>XII. СОНГУУЛЬ АЖИГЛАЛТ</b> .....	<b>23</b>
<b>XIII. СОНГУУЛИЙН МАРГААН ШИЙДВЭРЛЭХ</b> .....	<b>23</b>
<b>XIV. СОНГУУЛИЙН ӨДӨР</b> .....	<b>25</b>
A. НЭЭЛТ БА САНАЛ ӨГӨХ ҮЙЛ ЯВЦ.....	25
B. САНАЛ ТООЛОХ, ДҮНГ НЭГТГЭХ.....	26
<b>XV. СОНГУУЛИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВЦ</b> .....	<b>27</b>
<b>XVI. ЗӨВЛӨМЖ</b> .....	<b>27</b>
A. НЭН ТЭРГҮҮНИЙ ЗӨВЛӨМЖҮҮД .....	28
B. БУСАД ЗӨВЛӨМЖҮҮД.....	29
<b>ХАВСРАЛТ I: СОНГУУЛИЙН ЭЦСИЙН ҮР ДҮН</b> .....	<b>31</b>
<b>ХАВСРАЛТ II: ОЛОН УЛСЫН СОНГУУЛЬ АЖИГЛАХ ХОРООНД АЖИЛЛАСАН АЖИГЛАГЧДЫН ЖАГСААЛТ</b> .....	<b>34</b>
<b>АИХЭГ-ЫН ТУХАЙ</b> .....	<b>40</b>

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬ

2024 оны 6-р сарын 28.

АИХЭГ-ын сонгууль ажиглах хорооны тайлан<sup>1</sup>

## I. ХУРААНГУЙ

Монгол Улсын эрх бүхий байгууллагын урилга, ЕАБХАБ-ын Ардчилсан Институт Хүний Эрхийн Газрын (АИХЭГ) чиг үүргийн хүрээнд 2024 оны 6 дугаар сарын 28-ны өдөр болсон Улсын Их Хурлын (УИХ) сонгууль ажиглах хороог (САХ) байгуулан ажиллалаа. Сонгуулийн өдрийн үеэр хийсэн богино хугацааны сонгууль ажиглалтад АИХЭГ-ын САХ-ны багт Европын Парламентын төлөөлөгчид нэгдэн Олон Улсын Сонгууль Ажиглах Хороог (ОУСАХ) байгуулан ажиглав. ОУСАХ сонгуулийн үйл явц ЕАБХАБ-ын, болон ардчилсан сонгуульд тавигдах олон улсын стандарт, үүрэг амлалтууд, үндэсний хууль тогтоомжид нийцсэн эсэхийг үнэлсэн.

ОУСАХ 6 дугаар сарын 29-ний өдөр гаргасан Урьдчилсан үр дүн, дүгнэлтийн талаарх мэдэгдэлд, “сонгууль сайн зохион байгуулалттай болсон ч тэгш өрсөлдөх нөхцөл бүрдээгүй нь сонгуулийн өрсөлдөөнд сөрөг нөлөөлсөн. Эрх зүйн орчин ардчилсан сонгууль явуулахад тохирохуйц байсан боловч цаашид хүний үндсэн эрх, эрх чөлөөг олон улсын стандартад илүү нийцүүлэх шаардлагатай байна. Сонгуулийн байгууллага сонгогчдын боловсролын иж бүрэн хөтөлбөр хэрэгжүүлж, олон нийтийн итгэлийг хүлээж, мэргэжлийн ажилласан. Өрсөлдөгчид нийгмийн сүлжээнд болон бусад хэд хэдэн хязгаарлалтаас үл хамааран чөлөөтэй сурталчилгаа явуулж чадсан ч, сонгуулийн албан ёсны сурталчилгааны хугацаа богино байсан нь нөөц ихтэй, тогтсон намуудад давуу тал болсон. Түүнчлэн, сонгууль угтаж цалин нэмэх гэх мэт нийгмийн халамжийн хэд хэдэн хөтөлбөр нь эрх баригч намд үлэмж давуу байдлыг бий болгов. Оролцогч талууд сонгогчдын нэрийн жагсаалт сонгогчдыг бүрэн хамруулсан байдалд итгэл төгс байсан хэдий ч уурхайн талбарт ажилладаг иргэд гэх мэт сонгогч бүр санал өгөх боломжоор хангагдаж буй эсэхэд санаа зовниж байсан юм. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл өргөн хүрээнд ажилласан ч мэдээ сурвалжилга, дүн шинжилгээ бүхий мэдээний хөтөлбөрийн хязгаарлагдмал байдал, эрх баригч намыг илүү дэмжсэн байр суурь нь сонгогч мэдээлэлд суурилан сонголт хийх чадварт сөрөг нөлөөлөв. Сонгуулийн өдөр санал хураах үйл явц эмх цэгцтэй, саадгүй явагдаж, санал тоолох автоматжуулсан тооллого ил тод, шуурхай мэдээлэгдсэн боловч хэд хэдэн хэсгийн хороонд саналын хуудас нэгтгэх, саналыг баталгаажуулах үйл явцад холбогдох журмыг бүтэн мөрдөөгүй нь санал тоолоход сөрөг нөлөө үзүүлээ” хэмээн дүгнэсэн.

2023 оны 5 дугаар сард парламентыг илүү хүчирхэг, олон талт байдлыг хангасан болгох зорилгоор Үндсэн хуульд томоохон өөрчлөлт оруулж, парламентын гишүүдийн тоог 76-аас 126 болгон нэмэгдүүлж, холимог тогтолцоонд шилжсэний дараа УИХ-ын сонгууль боллоо. Эрх баригч Монгол Ардын Нам (МАН) 1990-ээд онд ардчилсан шилжилт хийгдсэнээс хойш улс төрийн орчинд ноёлсон бөгөөд өнгөрсөн 8 жилийн хугацаанд тасралтгүй засагласан. Өндөр түвшний улс төрчид холбогдсон авлигын хэрэг, хөдөөгийн малчин иргэд эдийн засгийн хүндрэлтэй тулгарсан үед сонгууль болж өнгөрлөө. Ардчилалд эерэг хандлагатай, улс төр, иргэний оролцоо өндөртэй боловч, залуус сонгуулийн идэвх бага буй нь анхаарууштай асуудал байв.

УИХ-ын 78 гишүүнийг сонгуулийн 13 мажоритар тойргоос, үлдсэн 48 гишүүнийг үндэсний хэмжээний нэг тойргоос хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгов. Хуульд сонгуулийн тойргийг зааглах төрөл бүрийн шалгуурыг тусгасан хэдий ч, сонгуулийн тойргийн хэмжээ жигд бус, улмаар сонгогчдын саналын үнэ цэн тэнцүү байхад сөрөг нөлөөлсөн нь олон улсын стандарт,

<sup>1</sup> Энэхүү тайлангийн Англи хэл дээрх хувилбар нь албан ёсны баримт бичиг юм. Албан бус орчуулгыг Монгол хэл дээр унших боломжтой.

ЕАБХАБ-ын үүрэг амлалттай зөрчилдсөн. Эрх зүйн орчин ардчилсан сонгууль явуулахад тохирохуйц байсан боловч цаашид хүний үндсэн эрх, эрх чөлөөг олон улсын стандартад илүү нийцүүлэх шаардлагатай байна. 2023 онд хийгдсэн эрх зүйн өөрчлөлт улс төрийн намын санхүүжилт, нэр дэвшигчдийн болон намын гүйцэтгэх байгууллагад хүйсийн квотыг нэмэгдүүлсэн эерэг өөрчлөлтүүдийг авчирсан. Гэвч, санал өгөх, нэр дэвших эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх, хэвлэлийн эрх чөлөө, сонгуулийн маргааныг шүүхээр шийдвэрлэх хугацаа гэх мэт АИХЭГ-аас олон жил гаргаж буй зөвлөмжүүд шийдвэрлэгдээгүй хэвээр байна.

Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ) мэргэжлийн түвшинд, хуульд заасан хугацааг ерөнхийдөө даган мөрдөж ажилласан. АИХЭГ-ын САХ-ны уулзсан хүмүүс сонгууль эрхэлсэн байгууллагад итгэдэг төдийгүй алагчлалгүй, ил тод байдлаар ажилладаг гэдгийг дурдсан юм. Гэвч, СЕХ цаашид үйл ажиллагаагаа илүү ил тод болгоход илүү хүчин чармайлт гаргах боломжтой. САХ СЕХ болон анхан шатны сонгуулийн хороодын хурлуудын дийлэнхэд уригдаагүй, хурлын тэмдэглэл олон нийтэд нийтлэгдээгүй нь ил тод байдлыг хязгаарлаж буй хүчин зүйл юм. СЕХ болон Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо (АНСХ) залуу сонгогчдыг оруулаад сонгогчдын боловсролын иж бүрэн кампанит ажлыг цахим платформ, уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сонгогчидтой хийх арга хэмжээнүүдээр дамжуулан явуулав. Хууль болон бусад арга хэлбэрээр бие эрхтний бэрхшээлтэй иргэд хараат бус, нууцаар санал өгөх эрхээ эдлэх боломжоор хангасан боловч, маш олон санал авах байр хүртээмжгүй хэвээр байсан юм.

Бүх санал авах байранд сонгуулийн өдөр оффлайн горимд ажилладаг, санал тоолж дууссаны дараа сүлжээнд холбогдож урьдчилсан үр дүнг СЕХ-нд дамжуулдаг санал тоолох төхөөрөмжүүдийг (СТТ) суурилуулжээ. Зарим оролцогч талууд машинд суурилсан санал тоолох үйл явцын оновчтой байдалд эргэлздэгээ илэрхийлсэн ч, түүнийгээ нотлох ямар нэг баримт гаргаж чадаагүй. Ил тод байдлыг хангах зорилгоор СЕХ санал тоолох төхөөрөмжийг турших арга хэмжээг сонгуульд өрсөлдөгчид, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн төлөөллийг оролцуулаад сонгууль болохоос хэдэн хоногийн өмнө олон нийтэд нээлтэй зохион байгуулсан. АИХЭГ-аас өмнө нь зөвлөмж гаргаж байсан хэдий ч, СТТ-ийн техникийн болон программ хангамжийн хувьд хөндлөнгөөс баталгаажуулах, нарийвчилсан үйл явцыг хуульд тусгаагүй байна.

Ойролцоогоор 2,2 сая сонгогч бүртгэгджээ. Сонгогчийн нэрийн жагсаалтыг Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас (УБЕГ) байнга шинэчилдэг хүн амын мэдээллийн нэгдсэн сангаас татаж авдаг. Сонгуулиас өмнө 136,000 орчим иргэн сонгогчийн бүртгэлээ баталгаажуулж, 8,000 орчим сонгогч мэдээллээ засуулах хүсэлт гаргасны дийлэнхийг нэг болон хэд хэдэн үл мэдэгдэх иргэд өөрийнх нь хаяг дээр бүртгэгдсэн байсан зөрчил эзэлжээ. АИХЭГ-ын САХ-ны ярилцсан зарим хүн олон тооны сонгогч сонгууль болохоос хэдэн сарын өмнө сонгуулийн үр дүнд нөлөөлөхийн тулд хаягаа шилжүүл гэсэн ажил олгогчийн шахалтад өртөж байж болзошгүй талаар мэдээлсэн. АИХЭГ-ын САХ-ны ярилцсан зарим хүн ерөнхийдөө сонгогчдын нэрийн жагсаалтад сонгогчдыг хамруулсан гэдэгт итгэж буйгаа илэрхийлсэн ч, УБЕГ-аас сонгогчдын бүртгэлийг шинэчилсэн талаарх мэдээлэл өгөхгүй, ил тод байдлыг хангахгүй байгаад санаа зовниж байсан юм.

Санхүүгийн болон эрх зүйн чадамж зэрэг нэр дэвших эрхийг хязгаарласан хэд хэдэн хязгаарлалт хууль тогтоомжид тусжээ. Сонгуульд өрсөлдөгч улс төрийн намуудын мөрийн хөтөлбөр Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцэх төдийгүй Үндэсний Аудитын Газраар (ҮАГ) батлуулах бөгөөд энэ шаардлага нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж, улс төрийн олон ургалч үзлийг боомилоход хүргэж болзошгүй. 6 дугаар сарын 10-ны өдөр СЕХ энэ сонгуулийн аль аль өрсөлдөөнд 19 нам, 2 эвсэл 42 бие даагч нийт 1,336 нэр дэвшигчийг бүртгэсэн талаар мэдээлсэн. СЕХ нэр дэвшигчдийн бүртгэлийг холбогдох журмын дагуу зохион байгуулж, нэр дэвшигчдийн материалыг залруулах боломжийг олгосон хэдий ч нэр дэвшигчид тавих хэд хэдэн хязгаарлалт, хатуу шаардлагууд нь нэр дэвших үйл явц бүхнийг хамруулсан шинжийг хадгалж буй эсэхэд эргэлзээ төрүүлж байна.

Өрсөлдөгчид кампанит ажлаа чөлөөтэй явуулж чадаж байсан ч, нам гүм кампанит ажил тэгш өрсөлдөх боломжийг хязгаарлав. Сонгуулийн кампанит ажлын богино хугацаанд, сонгуулийн том тойрогт сонгогчдод хүрч кампанит ажил явуулахад хэдийнээ бэхэжсэн улс төрийн намуудад илэрхий давуу талтай байсан бол жижиг улс төрийн намууд нийгмийн сүлжээ, сайн дурынханд найдан кампанит ажлаа явуулсан. Цахим сурталчилгаа АНСХ-нд бүртгэгдсэн цахим хуудас, нийгмийн сүлжээний хаягаар хязгаарлагдаж байсан нь улс төрийн мэтгэлцээнийг сааруулж, үг хэлэх эрх чөлөөг хязгаарлах боломжтой тул олон улсын стандарттай зөрчилдөж байв. Сонгууль дөхсөн үед засгийн газраас цалин, нийгмийн хамгааллын хөтөлбөрүүд хэрэгжүүлж, хэд хэдэн төрийн албан хаагч тэдгээрийг хөтөлбөрийг сурталчилсан нь эрх баригч намын кампанит ажилд чухал байр суурь эзэлж байсан нь төр, улс төрийн нам хоорондын ялгааг бүдгэрүүлж, ЕАБХАБ-ын үүрэг амлалттай зөрчилдсөн. Төрийн албан хаагчдад эрх баригч намыг дэмжихийг үүрэгдсэн маш олон мэдээлэл ирсэн нь сонгогч ямар нэг дарамтаас ангид сонголт хийж чадаж буй эсэхэд эргэлзээ үүсгэв. Хүчирхийллийн улмаас сумын намын хорооны дарга харамсалтайгаар амиа алдсан тохиолдол гарсан юм.

ҮАГ кампанит ажлын санхүүжилтийг хянаж, сонгуулийн тойргийн хэмжээ, хүн ам зүйн байдалд үндэслэн зарцуулж болох дээд хязгаарыг тогтоодог. АИХЭГ-ын САХ-ны ярилцсан хүмүүс сонгуулийн зардлын хязгаар хэт өндөр буй нь хэдийнээ бэхэжсэн, УИХ-д суудалтай улс төрийн нам, санхүүгийн боломж ихтэй нэр дэвшигчдэд илэрхий давуу тал олгож буйг дурдсан. ҮАГ кампанит ажлын санхүүжилт, түүний зарцуулалтыг хянах хуулийн эрх, үүрэгтэй боловч мониторингийн хийгээгүй нь улс төрийн намын эгэх хариуцлагын талаарх хуулийн зохицуулалтын үр дүнг бүдгэрүүлэв. ҮАГ нь хууль хэрэгжүүлэх эрх мэдэл хязгаарлагдмал, аливаа зөрчлийн талаарх мэдээллийг бусад байгууллагууд руу шилжүүлж байлаа. Ерөнхийдөө, сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн талаарх хуулийн зохицуулалтад санхүүжилтийг хянах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр дүнтэй механизм дутмаг байна.

Үндсэн хуульд жендэрийн тэгш байдлыг баталгаажуулсан хэдий ч, жендэрийн хэвшмэл ойлголт, одоогийн болон ирээдүйн бодлого боловсруулагч эмэгтэйчүүдийн нөөц хязгаарлагдмал зэргээс улс төрийн амьдралд эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй байна. Сонгууль эрхэлсэн байгууллагын анхан шатны түвшинд эмэгтэйчүүд хангалттай төлөөлөгдсөн боловч АНСХ-нд тэдний төлөөлөл хангалтгүй, СЕХ-ны ердөө ганцхан гишүүн нь эмэгтэй байна. Бүртгэгдсэн 1,336 нэр дэвшигчийн 519 нь эмэгтэйчүүд байлаа. Нэр дэвшигчид үндэсний хэмжээнд идэвхтэй кампанит ажил явуулсан ч, эмэгтэйчүүдэд чиглэсэн улс төрийн мессеж бараг л байсангүй. Шинээр бий болсон УИХ-д эмэгтэйчүүдийн төлөөлөл 17 хувиас 25 хувь болж өссөн.

Харьцангуй жижиг арилжааны зах зээл бүхий хэвлэл мэдээллийн салбар олон ургалч боловч, улс төрийн харьяалал, эдийн засгийн хязгаарлагдмал нөөц зэрэг нь маш олон редакцын хараат бус байдлыг бүдгэрүүлдэг. Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз (МҮОНРТ) олон нийтэд харьцангуй танигдсан бөгөөд сонгууль дөхөх үед хэдий оргил цагаар биш ч гэлээ эфирийн цагаа нэр дэвшигчдэд олгож, олон тооны мэтгэлцээн зохион байгуулсан. Гэсэн хэдий ч, эрэн сурвалжилсан, задлан шинжилсэн мэдээ, сурвалжилгууд дутмаг, төдийгүй мэдээ, сурвалжилгын хязгаарлагдмал байдал сонгогчдын мэдээлэлд үндэслэн сонголт хийх чадварыг сулруулсан. Сонгуулийн үеэр хийсэн хэвлэл мэдээллийн мониторингоос үзэхэд МҮОНРТ болон хэд хэдэн хувийн телевизийн сувгууд эрх баригч намд эфирийн цаг олгожээ. 2020 худал мэдээлэл түгээх хуулийн заалтыг сэргээсэн нь хэд хэдэн сэтгүүлчийг эрүүгийн хариуцлагад татахад хүргэв. Ерөнхийдөө, эрх зүйн орчин, хуулийн хэрэгжилт эрэн сурвалжлах сэтгүүл зүйг боомилсноос сэтгүүл зүй өөрийгөө цензурдэхэд хүрч, олон нийтэд сөргөөр яригдаж байна.

Хуульд иргэний болон олон улсын ажиглалтыг тусгасан. Улс төрийн нам, эвслүүд санал авах байранд ажиглагч томилж болно. Сонгууль ажиглах иргэний бүртгэлийг хөнгөвчлөхийн тулд СЕХ тэднийг ажиглах хэсгийн хороогоо тодорхойлж, цахим платформд бүртгэлээ хийхийг

шаарддаг. Гэсэн хэдий ч, сонгуулийн хэсгийн хорооны ажилчид иргэний ажиглагчдаас нэмэлт бичиг баримт асуусан нь шаардлагагүй алхам бөгөөд үйл явцыг төвөгтэй болгож байсан юм. Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн эвсэл сонгогчийн бүртгэл, сонгуулийн сурталчилгаа, кампанит ажлын санхүүжилт, болон сонгуульд технологийн хэрэглээ зэргийг ажиглав.

Сонгуультай холбоотой хэрэг маргааныг түргэтгэсэн байдлаар шүүн шийдвэрлэх журам байхгүй. Харин, захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ерөнхий хуулийн хугацааг баримталдаг. Шүүх сонгуультай холбоотой маргааныг түргэн шийдвэрлэхийг эрмэлзэх хэдий ч, шийдвэрлэх хугацаа нь сонгуулийн цаг хугацааны хуваарьтай нийцэхгүй тул, зөрчигдсөн эрхийг сэргээх ажлын үр нөлөөг бүдгэрүүлдэг. Сонгуулийн өмнө, улс төрийн нам, нэр дэвшигчийн бүртгэлтэй холбоотой 15 нэхэмжлэл Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд иржээ. Үүнээс 5 нэхэмжлэхийг шууд хүлээн авахаас татгалзсан ба, шүүхээр шийдвэрлүүлсэн 10 маргааны 5-ын нэхэмжлэлийн шаардлагыг хангах СЕХ-ны шийдвэрийг хүчингүй болгож, нэр дэвших боломжоор хангасан хэдий ч дийлэнх нь сонгуулийн сурталчилгааны хугацаа эхлээд талдаа орсон байхад шийдвэрлэгдсэн юм. Сонгуулийн дүнг зарласны дараа СЕХ 20 гаруй гомдол, хүсэлт ирсний дийлэнх нь суудал хуваарилах босгыг эсэргүүцсэн бөгөөд аль хэдийнээ олон нийтэд ил болсон мэдээллийг СЕХ-ноос шаардсан хүсэлтүүд байв.

Сонгуулийн өдөр тайван, эмх цэгцтэй, санал өгөх үйл явц журмын дагуу болж өнгөрсөн. Гэсэн хэдий ч, санал авах байрны зохион байгуулалт, санал тоолох төхөөрөмжийн байршил, зарим хэсэгт хэт ачаалал үүссэнээс саналын нууцлал алдагдах зэрэг зөрчил ажиглагдав. Сонгуулийн хэсгийн хороодын албан ёсны дүн даруй тоологдож, СЕХ-ны төв сервер рүү зохих журмын дагуу дамжуулагдсан. Гэсэн хэдий ч, санал хураалт хаагдах, хяналтын гар тооллого хийх үйл явц журмыг ягштал дагаагүй хэд хэдэн тохиолдол ажиглагдсан нь ОУСАХ-ны ажиглагчид тус үйл явцыг сөргөөр үнэлэхэд хүргэжээ. АИХЭГ-аас өмнө нь зөвлөмжүүд гаргаж байсан хэдий ч, СЕХ-ноос нийтэлсэн эцсийн үр дүн нь санал авах байр тус бүрээр ангилагдаагүй, зөвхөн өгсөн саналын мэдээллийг багтааж, санал авах байр тус бүрийн сонгогчийн ирц, бүртгэгдсэн сонгогчид гэх мэт сонгуультай холбоотой бусад мэдээллийг орхисон нь сонгуулийн үр дүнгийн ил тод байдлыг бууруулж байна.

Энэхүү тайлан нь Монгол Улс сонгуулиа ардчилсан сонгуулийн талаарх ЕАБХАБ-ын үүрэг амлалт, бусад олон улсын стандарт, үүрэг амлалтад ойртуулах хүчин чармайлтад тус болох хэд хэдэн зөвлөмжийг санал болгож байна. Тэргүүлэх зөвлөмжүүд нь сонгуулийн үйл явцыг олон улсын жишигт улам нийцүүлэхэд хуулийн нэмэлт, өөрчлөлтийг санаачлах, хяналтын тооллого зохион байгуулах, санал тоолох тогтолцоог гуравдагч талаар баталгаажуулах, захиргааны нөөцийг зүй бусаар ашиглах, кампанит ажлын санхүүжилтийн зөрчилд хариуцлага тооцох, худал мэдээлэл түгээхтэй холбоотой эрүүгийн хуулийн заалт, сонгуулийн үр дүнтэй холбоотой маргааныг үр дүнтэй, цаг хугацаанд нь шийдвэрлэх зэрэгтэй холбоотой байна. АИХЭГ энэ болон өмнө тайлангуудад агуулагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэхэд эрх бүхий байгууллагад туслахад бэлэн байна.

## II. ТАНИЛЦУУЛГА, ТАЛАРХАЛ

2024 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн УИХ-ын сонгуулийг ажиглах урилга, өөрийн үндсэн эрхийн хүрээнд ЕАБХАБ-ын Ардчилсан Институт, Хүний Эрхийн Газар (АИХЭГ) Сонгууль Ажиглах Хороог (САХ) 5 дугаар сарын 21-ний өдөр байгуулав. Элчин сайд Женнифер Брашаар удирдуулсан 13 хүний бүрэлдэхүүнтэй үндсэн баг Улаанбаатар хотод, урт хугацааны 18 ажиглагч 5 дугаар сарын 28-ны өдрөөс улс даяар 8 байршилд ажиллав. АИХЭГ-ын САХ 7 дугаар сарын 9-ний өдрийг хүртэл Монголд байрлан ажилласан.

Сонгуулийн өдөр 13 гишүүнээс бүрдсэн Европын Парламентын (ЕП) төлөөлөгчид АИХЭГ-ын САХ-ны багт нэгдсэнээр Олон Улсын Сонгууль Ажиглах Хороог (ОУСАХ) бүрдүүлэв. Томас Здековский ЕП-ын төлөөлөгчдийг ахалсан юм. ОУСАХ-нд оролцсон байгууллагууд 2005 оны Олон Улсын Сонгууль Ажиглах Зарчмуудын Тунхаглалыг мөрдөн ажилласан. ОУСАХ ЕАБХАБ-ын 30 гишүүн улс орны 191 ажиглагчийг илгээснээс, 178 урт болон богино хугацааны ажиглагчийг АИХЭГ, 13 гишүүн төлөөлөгчийг ЕП-аас илгээв. ОУСАХ-ны ажиглагчдын 47 хувь нь эмэгтэйчүүд байлаа.

ОУСАХ сонгуулийн үйл явц ЕАБХАБ-ын, болон ардчилсан сонгуульд тавигдах олон улсын стандарт, үүрэг амлалтууд, үндэсний хууль тогтоомжид нийцсэн эсэхийг үнэлсэн. Энэхүү эцсийн тайлан нь 6 дугаар сарын 29-ний өдөр нийтлэгдсэн Урьдчилсан үр дүн, дүгнэлтийн талаарх мэдэгдлийн үргэлжлэл юм.<sup>2</sup>

АИХЭГ-ын САХ сонгууль ажиглах урилга өгсөн Монгол Улсын Засгийн газарт болон тусалж, хамтран ажилласан Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ), Гадаад Харилцааны Яаманд талархал илэрхийлж байна. Түүнээс гадна бусад төрийн байгууллагууд, шүүх, улс төрийн нам, хэвлэл мэдээллийн болон иргэний нийгмийн байгууллагууд, олон улсын хамтын нийгэмлэгийн төлөөлөгчдөд үзэл бодлоо илэрхийлж, хамтран ажилласанд талархал илэрхийлэе.

### Ш. ҮНДЭСЛЭЛ, УЛС ТӨРИЙН БАЙДАЛ

2023 оны 5 дугаар сард парламентыг олон талт байдал, төлөөллийг хүчирхэгжүүлэх зорилгоор Үндсэн хуульд томоохон өөрчлөлт оруулж, парламентын гишүүдийн тоог нэмэгдүүлж, холимог тогтолцоонд шилжсэний дараа 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр УИХ-ын сонгуулийн товыг зарласан.<sup>3</sup> Эрх баригч Монгол Ардын Нам (МАН) тусгаар тогтнолоос хойш улс төрийн тавцанд ноёлсоор ирсэн. Өнгөрсөн 8 жилийн хугацаанд, МАН сүүлийн хоёр удаагийн УИХ-ын сонгуульд үнэмлэхүй олонхын суудал авч, 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулснаар зор мэдлээ улам бататгав.<sup>4</sup> УИХ-д суудалтай хоёр дахь том нам Ардчилсан Нам (АН) дотоодын ноцтой хуваагдалтай тулгарч, энэ нь зарим талаар сонгууль хүртэл үргэлжилжээ.

Сүүлийн жилүүдэд авлига нь олон нийтийн дунд яригдсан хамгийн чухал сэдвүүдийн нэг байсан бөгөөд сонгуулийн өмнө өндөр түвшний албан тушаалтнуудын оролцсон хэд хэдэн нэхэмжлэл гарчээ.<sup>5</sup> 2022 оны 4 дүгээр сард, авлига, засгийн газрын үр ашиггүй байдлыг эсэргүүцсэн жагсаал, мөн 2022 оны 12 дугаар сард нүүрсний экспорттой холбоотой авлигын томоохон схем илчлэгдэхтэй зэрэгцэн томоохон жагсаал тус тус болов. Үүний хариуд, эрх баригчид УИХ-ын мөрдөн шалгах хороо байгуулж, хэд хэдэн өндөр түвшний албан тушаалтан, УИХ-ын гишүүдийг баривчилж, эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж авлигатай холбоотой гэмт хэргийн хариуцлагыг өндөрсгөлөө.

<sup>2</sup> АИХЭГ-аас Монголын сонгуулийн өмнөх тайлангуудыг [эндээс](#) үзнэ үү.

<sup>3</sup> Үндсэн хуулийн өөрчлөлтөөр УИХ-ын гишүүдийн тоог 76-аас 126 болгон нэмэгдүүлж, сонгуулийн тогтолцоо цэвэр мажоритараас холимог болон өөрчлөгдсөн.

<sup>4</sup> 2020 оны УИХ-ын сонгуулиар МАН 62, Ардчилсан нам (АН) 11, Та бидний эвсэл, Зөв Хүн Электорат эвсэл тус бүр нэг, бие даагч нэг суудлыг тус тус авсан. ХҮН намын нэр дэвшигч, Монголын Социал Демократ нам, Зүй ёс намын бүрдүүлсэн Зөв Хүн Электорат эвслээс сонгогдсон. Сонгуулийн өмнө, Засгийн газрын бүх 22 сайд, 21 аймгийн засаг даргын 14-ийг МАН-ын мэдэлд байв.

<sup>5</sup> 2023 оны 5 дугаар сард болсон боловсролын зээлийн сан, 2023 оны 6 дугаар сард Улаанбаатар хотын нийтийн тээвэрт зориулж 1000 автобусны худалдан авах үйл ажиллагаа, мөн 2024 оны 3 дугаар сард АНУ-ын Хууль зүйн яамнаас УИХ-ын гишүүн, Ерөнхий сайд асан Сүхбаатарын Батболд төрийн мөнгөөр 14 сая долларын (2024 оны 6 дугаар сарын ханшаар ойролцоогоор 12.9 сая евро) үнэтэй орон сууц Нью-Йорк хотод худалдаж авсныг [хураан авах](#) талаарх мэдэгдэл зэрэг хамаарна.

2023-2024 оны хахир, хатуу өвөл орон нутгийн малчин өрх, болон нийслэлийн эдийн засаг, дэд бүтцийн хувьд харьцангуй сул хэсгийн иргэдэд ихээхэн хүнд байдал учрууллаа. 2024 оны 4 дүгээр сард УИХ мал аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор нэн яаралтай горимоор шинэ хууль, тогтоомж батлав. Хууль батлах ердийн журмыг тойрсон төдийгүй эрх баригч намын ухуулагчид шинэ хууль тогтоомжийг ашиглан намаа сурталчилж буйг АИХЭГ-ын САХ-ны ярилцсан хүмүүс шүүмжилсэн юм.

Оролцогч талууд шүүхийн бие даасан байдал, сэтгүүлчдэд учрах дарамтын талаарх санаа зовнил энэ сонгуулиас ч өмнө байсаар байлаа.<sup>6</sup> Сүүлийн жилүүдэд иргэний нийгмийн байгууллагууд хязгаарлагдмал санхүүгийн болон хүний нөөц, төрийн дэмжлэг хангалтгүй, хүнд суртлаас үүдэх саад бэрхшээл, нийтийн оролцоо сул зэрэг олон сорилттой орчинд үйл ажиллагаа явуулж иржээ.<sup>7</sup>

Ялгаварлан гадуурхалтын эрсэг хуулийн заалтууд бий хэдий ч, улс төрийн амьдралд, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй хэвээр байна. Бүрэн эрх нь дуусаж буй УИХ-д 76 гишүүний 13 нь эмэгтэй (17 хувь), 22 сайдын ердөө 3 нь эмэгтэй (14 хувь), 22 засаг даргын ердөө нь 1 нь эмэгтэй байв. ОУСАХ-ны ярилцагчдын дийлэнхийн үзэж буйгаар жендэрийн хэвшмэл ойлголт, хязгаарлагдмал нөөц бололцоо нь ирээдүйд болон одоо шийдвэр гаргах түвшинд ажиллаж буй эмэгтэйчүүдэд улс төрийн амьдралд оролцоход саад тотгор үүсгэсээр буйг тэмдэглэсэн юм.

АИХЭГ-ын САХ-ны уулзсан хэд хэдэн хүн залуучуудын улс төрийн оролцоо хангалтгүй буй нь санаа зовоож буй асуудал хэмээн тодорхойлов.<sup>8</sup> Залуу сонгогчдын дунд улс төрийн намуудад сэтгэл дундуур байдал ихсэж буй боловч, ардчилсан тогтолцоонд итгэх хандлага эерэг хэвээр байна. Монгол Улс улс төрийн болон иргэний оролцоогоор дээгүүр байр суурь эзэлдгийг энд тэмдэглэх нь зүйтэй.<sup>9</sup>

#### IV. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН БА СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО

Монгол Улс ардчилсан сонгууль зохион байгуулахтай холбоотой томоохон олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орсон.<sup>10</sup> Монгол УИХ-ын сонгуулийн хууль, эрх зүйн орчин нь 1992 оны Үндсэн хууль, 2019 оны Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн Тухай Хууль (МУИХСтХ), 2006 оны Сонгуулийн төв байгууллагын тухай хууль, 2011 оны Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулиудаас бүрдэх бөгөөд эдгээр хуулиудад бүгдэд 2023 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Түүнчлэн, Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2023 онд батлагджээ.<sup>11</sup> Эрх зүйн орчин ерөнхийдөө ардчилсан сонгууль зохион байгуулахад хангалттай

<sup>6</sup> 2023 оны [Шүүгч, хуульчдын хараат бус байдлын асуудал эрхэлсэн НҮБ-ын тусгай илтгэгчийн урьдчилсан ажиглалт](#) үз.

<sup>7</sup> [Алшийн төлөө бус хуулийн олон улсын төв](#) өсөн нэмэгдэж буй иргэний нийгмийн салбарыг хамгаалахын тулд хуулиудыг уялдуулж, бэхжүүлэх шаардлагатайг онцолсон. Транспэрэнси Интернэшнл Монгол байгууллагын [2024 оны Иргэний Нийгмийн Тайланд](#) иргэний орон зайг хязгаарлаж, төсвийн баримт бичгийн хүртээмж багссан, хууль тогтоох үйл явцад олон нийтийн оролцоо хязгаарлагдмал, 2021 онд батлагдсан Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль хэрэгжээгүй хэвээр байгааг тэмдэглэжээ.

<sup>8</sup> 2024 оны байдлаар, Монголын залуучууд хүн амын 13,4 хувийг [эзэлж](#) байна.

<sup>9</sup> 2023 оны байдлаар [Дэлхийн Залуучуудын Хөгжлийн Индексээр](#) Монгол Улс 183 орноос 24-т эрэмбэлэгджээ. Мөн, Судалгаа, Шинжилгээний Инсайт Төвийн [2022 оны судалгааг](#) үзнэ үү.

<sup>10</sup> Үүнд, [1966 оны Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пакт](#), [1979 оны ЭМэгтэйчүүдийн алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц](#), [2003 оны Авлигын эсрэг НҮБ-ын конвенц](#), болон [2006 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц зэрэг багтана.](#)

<sup>11</sup> Үүнд, 2015 оны Эрүүгийн хууль, 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2016 оны Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 оны Зөрчлийн тухай хууль, 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хууль, 2016 оны Хөгжийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон 2006 оны Авлигын эрсэг хууль багтана.



хэдий ч, цаашид хүний үндсэн эрх, эрх чөлөө, сонгох эрхийг хамгаалах, сонгуулийн кампанит ажил явуулах, тэр дундаа хэвлэл мэдээлэл, сонгуулийн маргаан шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай.

МУИХСтХ-д сүүлд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь ерөнхийлөө сонгуулийн тогтолцоог өөрчилсөн Үндсэн хуулийн өөрчлөлтийг тусгажээ. МУИХСтХ-д, УИХ-ын сонгуульд гадаадад буй сонгогчид санал өгөх, улс төрийн нам, эвсэл, өрсөлдөгчдийг бүргэх үйл ажиллагаа, сонгогчдын нэрийн жагсаалтыг хөтлөх, шинэчлэх журам болон бусад олон өөрчлөлтүүдийг оруулсан. Сонгуулийн тов зарлагдсаны дараа байгуулагдсан улс төрийн нам сонгуульд оролцох, болон нэр дэвшигчийн хүйсийн квотыг өндөрсгөсөн зэрэг эерэг өөрчлөлтүүд тус хуульд тусжээ. Гэсэн хэдий ч, хуульд сонгох эрх, үгээ хэлэх эрх чөлөөг үндэслэлгүй хязгаарласан төдийгүй, хуулийн цоорхой, тодорхой бус зохицуулалтууд байсаар байна.<sup>12</sup> Сонгох эрхийг хязгаарласан, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх, хэвлэлийн эрх чөлөөг хязгаарласан, сонгуультай холбоотой маргааныг шүүхээр шийдвэрлэх хугацаатай холбоотой АИХЭГ-аас удаа дараа гаргасан зөвлөмжүүд шийдвэрлэгдээгүй орхигдсон хэвээр байна.

2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар нийт сонгогчийн 1 ба түүнээс дээш хувийн санал авсан намд төрийн санхүүжилт олгох гэх мэт олон улсын сайн жишигт тооцогдох хэд хэдэн өөрчлөлтүүдийг тусгажээ.<sup>13</sup> Тус хуульд намын удирдах байгууллага, бодлого, үйл ажиллагаандаа хүйсийн болон нийгмийн ялгаатай бүлгийн төлөөллүүдийг оролцуулах шаардлага тавьж буй нь сайшаалтай. Мөн, МУИХСтХ-д заасан квотоос илүү олон эмэгтэйг нэр дэвшүүлбэл улс төрийн намд санхүүгийн хөшүүрэг олгох зохицуулалтыг тусгажээ.

Гэсэн хэдий ч, Улс төрийн намын тухай хуульд улс төрийн намын бүтэц, дотоод зохион байгуулалтыг хэт зохицуулсан, улс төрийн намын гишүүнчлэлийг зөвхөн сонгуулийн эрхтэй иргэдээр хязгаарласан зохицуулалтыг агуулж байна.<sup>14</sup> Түүнчлэн, хуулиар нарийн тодорхойлоогүй "төрийн жинхэнэ албан хаагч" гэх нэр томъёог ашигласан нь өргөн утгаараа бүх төрийн албан хаагчдад нөлөөлөх боломжтой.<sup>15</sup> Энэ нь олон улсын жишигтэй зөрчилдөж, эвлэлдэн нэгдэх эрхээ эдлэх боломжид сорилт учруулж буй юм.<sup>16</sup> Мөн, тус хуульд намын дүрмийн агуулга, үйл ажиллагаа, шийдвэр гаргах үйл явцыг хэт нарийн зохицуулжээ. Цаашлаад, намын үндсэн дүрэмтэй холбоотойгоор намыг бүртгэхээс татгалзах үндэслэлүүдийг хуульд

<sup>12</sup> Тухайлбал, саналын хуудсыг гараар тоолох хуулийн шаардлагатай бөгөөд гараар тоолоход зөрүү үүссэн тохиолдолд хэрхэх тухай хуульд хангалттай зохицуулаагүй, мөн, нэр дэвшигчийн бүртгэлийг цуцлах, сонгуультай холбоотой маргааныг шийдвэрлэх талаар нарийн зохицуулаагүй байна.

<sup>13</sup> Төрийн санхүүжилтийн 50-аас доошгүй хувийг эмэгтэйчүүд, ахмадууд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоог дэмжих, намын гишүүд, болон олон нийтийг сургах, ардчилал, хүний эрх, дотоод ардчиллыг бэхжүүлэх гэх мэт зорилгоор зарцуулах ёстой.

<sup>14</sup> 2022 онд [АИХЭГ болон Венецийн Комиссын Улс төрийн намын тухай хуулийн төсөлд өгсөн хамтарсан зөвлөмжийн улс төрийн намыг байгуулах дэмжихэд тавьсан хязгаарлалтыг хасах талаарх](#) 35 – 38 дугаар догол мөрийг үзнэ үү.

<sup>15</sup> Улс төрийн намын тухай хуулийн 5.3-р зүйл. Мөн [АИХЭГ болон Венецийн Комиссын Улс төрийн намын тухай хуулийн төсөлд өгсөн хамтарсан зөвлөмжийн](#) 50-р догол мөрд “улс төрийн намын тухай хуулийн төсөлд улс төрийн намын гишүүнчлэлийг хориглосон “төрийн жинхэнэ албан хаагч” гэдгийг тодорхойлох, эсвэл холбогдох хуулийн заалттай холбон тайлбарлах шаардлагатай гэснийг үзнэ үү.

<sup>16</sup> [1990 оны ЕАБХАБ-ын Копенхагены баримт бичгийн](#) 7.6 дахь догол мөрд Гишүүн улсууд “сонгуульд оролцогчдыг хууль болон эрх бүхий байгууллагуудын өмнө эрх тэгш өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай хууль эрх зүйн баталгаагаар хангана” гэж заасан байдаг. [ИБУТЭОУП-ын](#) 25-р зүйлд иргэн бүр төрийн хэрэгт оролцох эрхийг баталгаажуулсан. ИБУТЭОУП-ын 25-р зүйлд өгсөн 1996 оны [Ерөнхий Санал дүгнэлтэд](#) намын гишүүнчлэл сонгуулийн явц, төрийн үйл хэрэгт оролцоход онцгой үүрэгтэй. Улс төрийн нам дотоод удирдлагадаа тус пактын 25-р зүйлд заасан эрхийг иргэд эдлэх боломжоор хангах, хүндэтгэх ёстой” гэжээ. Мөн [2022 оны АИХЭГ, Венецийн комиссын Улс төрийн намын тухай хуульд өгсөн хамтарсан зөвлөмж](#) үзнэ үү.

тогтоож өгсөн байна.<sup>17</sup> Түүнчлэн, Улсын Дээд Шүүх намын бүртгэхээс татгалзсан тохиолдолд намын зөрчигдсөн эрхийг сэргээх талаар ямар нэг зохицуулалт үгүй байна.<sup>18</sup>

*Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, улс төрийн олон ургалч үзэл, бие даасан байдлыг баталгаажуулахын тулд хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулж улс төрийн намын гишүүнчлэл, намын дотоод зохион байгуулалтад тавьсан шаардлагагүй хязгаарлалтуудыг арилгах ёстой.*

*Хуулийн хохирол барагдуулах үр дүнтэй механизмыг бий болгохын тулд улс төрийн намыг бүртгэхээс татгалзсан тохиолдолд хуулийн хамгаалал хүсэх бололцоог олгох зохицуулалтыг нэмэлт, өөрчлөлтөөр тусгах эсэхийг анхаарч үзэх хэрэгтэй.*

УИХ-ын 78 гишүүнийг сонгуулийн 13 тойргоос олныг төлөөлөх аргаар, үлдсэн 48 гишүүнийг Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн нэг тойргоос хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.<sup>19</sup> Сонгуулийн тойрог бүрд УИХ-ын гишүүдийг сонгогчид тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг (багц санал) сонгоно. Сонгуулийн тойрог байгуулах тухай УИХ-ын тогтоолд шалгуур үзүүлэлтийг нарийн дурдаагүй боловч, МУИХСтХ-д сонгуулийн тойрог байгуулахдаа хүн амын тоо, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, газар нутгийн хэмжээ, байршил зэргийг харгалзан байгуулахаар заасан. Сонгуулийн 13 тойргийн арван нэгийнх нь сонгогчдын тоо сонгогчдын дундаж тооноос хамгийн багадаа 15 хувиар хэтэрсэн бол, Улаанбаатар хотын дөрвөн тойрог 50 хувиар хэтэрчээ. Энэ зөрүүтэй байдал нь сонгуулийн тойргоос үл хамааран саналын үнэ цэн ижил тэгш байхад сөрөг нөлөөлж, ЕАБХАБ-ын үүрэг амлалт, сонгуулийн сайн туршлага болон АИХЭГ-ын өмнөх зөвлөмжүүдтэй зөрчилдөж байна.<sup>20</sup>

*Өмнө нь зөвлөмж гаргаж байсанчлан, саналын тэгш байдлыг хангахад олон нийтийн хил хязгаарыг хадгалахад анхаарч, сонгуулийн тойрогт ногдох сонгогчдын дундаж тооноос гажуудаж болох дээд хязгаарыг үндэслэлтэйгээр тодорхойлж хуульчлах ёстой.*

## V. СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА

Сонгуулийг дөрвөн шат бүхий сонгуулийн байгууллага зохион байгуулна. СЕХ нь байнгын ажиллагаатай, 9 гишүүнээс бүрдэх байгууллага бөгөөд ердөө нэг эмэгтэй гишүүнтэй. СЕХ-ны гишүүд 6 жилийн хугацаатай томилогдох төрийн албан хаагчид ба улс төрийн намын гишүүн байж болохгүй. УИХ СЕХ-ны 5 гишүүнийг, Ерөнхийлөгч, Улсын Дээд Шүүх тус бүр 2

<sup>17</sup> 2020 онд АИХЭГ, Венецийн Комиссын [Улс төрийн намын эрх зүйн зохицуулалтын хамтарсан удирдамжийн](#) 116-р догол мөрд: “Улс төрийн нам нь хоёр нөхцөлийн үндсэн дээр хууль, эрх зүйн болон үндсэн хуулийн бүтцийн өөрчлөлтийг дэмжих боломжтой байх ёстой. Нэгдүгээрт, энэ зорилгоор ашиглах арга зам нь хуулийн дагуу бөгөөд ардчилсан байх, хоёрдугаарт, санал болгож буй өөрчлөлтүүд ардчиллын суурь зарчмуудад нийцсэн байх” гэснийг үзнэ үү.

<sup>18</sup> Улс төрийн намыг бүртгэхээс татгалзах нь захиргааны шийдвэр тул 1990 оны ЕАБХАБ-ын Копенхагены Баримт бичгийн 5.10 дахь догол мөрд “суурь эрхээ эдлэх, хуулийн шударга байдлыг хангахад чухал үүрэгтэй тул хүн бүр захиргааны шийдвэрийн эсрэг эрхээ сэргээлгэх үр дүнтэй арга хэрэгслээр хангагдах ёстой” гэж заасныг тэмдэглэх нь зүйтэй. 2020 онд АИХЭГ, Венецийн Комиссын [Улс төрийн намын эрх зүйн зохицуулалтын хамтарсан удирдамжийн](#) 154-155-р догол мөрд: “Ерөнхийдөө улс төрийн намд тавих төрийн хяналт хамгийн бага хэмжээнд байх ёстой бөгөөд ардчилсан нийгэмд шаардлагатай зүйлээр л хязгаарлагдах ёстой... Дүгнэж хэлбэл, улс төрийн намын үйл ажиллагаа, тухайлбал, гишүүнчлэл, намын их хурал, хурлын тоо, давтамж, орон нутаг дахь салбар, нэгжийн үйл ажиллагаа зэрэгт улс төрийн болон бусад хэрээс хэтэрсэн хяналт тавихаас зайлсхийх хэрэгтэй” гэжээ.

<sup>19</sup> Мажоритар тойргийн тоо 29-өөс 13 болж цөөрсөн.

<sup>20</sup> ЕАБХАБ-ын 1990 оны Копенхагены баримт бичгийн 7.3 дахь догол мөрд төр улсууд насанд хүрсэн иргэддээ сонгох эрх олгохыг шаарддаг. Венецийн комиссын 2002 оны [Сонгуулийн асуудлаарх сайн туршлагын эмхэтгэлд](#) нормоос зөвшөөрөгдөх дээд хэмжээ 10 хувиас ихгүй байх, нэн онцгой нөхцөлд 15 хувиас хэтрэхгүй байх тухай зөвлөжээ.

гишүүнийг нэр дэвшүүлнэ.<sup>21</sup> СЕХ доод шатны сонгуулийн хороодыг томилох, нэр дэвшигчийг бүртгэх, саналын хуудасны загвар гаргах, хэвлэх, сонгуулийн үр дүнг гаргах, санал тоолох автоматжуулсан системийн хэвийн ажиллагааг хангах хэрэгжүүлэх зэрэг сонгууль зохион байгуулахтай холбоотой олон үүрэг хүлээдэг. СЕХ ерөнхийдөө алагчлалгүй, хуулийн хугацаанд нийцүүлж, мэргэжлийн байдлаар ажилладаг.

4 дүгээр сарын 29-ны байдлаар СЕХ аймаг, нийслэлийн сонгуулийн 22 хороо (АНСХ), сум, дүүргийн 339 сонгуулийн хороо (СДСХ) байгуулагджээ.<sup>22</sup> Сонгуулийн хэсгийн 2198 хороог (СХХ) 5 дугаар сарын 14-ний өдрийн дотор байгуулах ажил СЕХ-ны цахим систем нэвтрүүлэх ажлаас болж хойшлогдсон хэдий ч, сонгуулийн бэлтгэл ажилд нөлөөлөөгүй.<sup>23</sup> СДСХ, СХХ-ны түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл сайтар хангагдаж, нийт албан хаагчдын 76 хувийг эзэлж байсан бол, АНСХ-ны гишүүдийн ердөө 9 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. СХХ-ны гишүүд сонгуульд ажиллахын тулд цахим сургалтыг дүүргэж, гэрчилгээ авсан байх ёстой. СДСХ-ноос СХХ-нд зориуд нэмэлт танхимын сургалт зохион байгуулсан нь үндсэндээ сонгуулийн өдрийн үйл явцад голлон анхаарчээ.

АИХЭГ-ын САХ-ны ярилцсан дийлэнх хүмүүс бүх шатны сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагаанд итгэлтэй байгаагаа илэрхийлж, алагчлалгүй, ил тод ажилладгийг онцлон тэмдэглэсэн хэдий ч, илүү хүчин чармайлт гаргаснаар үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх боломжтой байна. СЕХ гаргасан шийдвэр, журмуудаа өөрсдийн цахим хуудсанд байршуулж, сонгогчдын боловсрол, мэдээлэл өгөх материалуудыг түгээж ажилласан. Гэсэн хэдий ч СЕХ-ны болон доод шатны сонгуулийн хороодын хуралдаан олон нийтэд зарлагдаагүй юм. СЕХ-ны хуралдааны тэмдэглэл нийтлэгдсэн ч, доод шатны сонгуулийн хороодынх нээлттэй байршаагүй. Сонгууль хүртэл СЕХ танхимын хоёр удаагийн, цахим гурван удаагийн хуралдаан хийсэн байна.<sup>24</sup>

*Ил тод байдлыг хангах, олон нийтийн сонирхсон мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэхийг тулд бүх шатны сонгуулийн хороод нээлттэй хуралдаан хийх, хурлын хөтөлбөр, шийдвэр, тэмдэглэлүүдийг олон нийтэд мэдээлэх ажлыг цаг тухайд нь, тасралтгүй нийтэлж байх ёстой.*

СЕХ сонгуулийн өдрийн үйл ажиллагаа, сонгуулийн тогтолцоог тайлбарласан, саналын хуудсыг бөглөх зааварчилгаа гэх мэт сонгогчдын боловсролд зориулсан иж бүрэн кампанит ажиллагаа явуулсан. СЕХ сонгогчид мэдээлэл өгөх брошюр айл бүрд тараасан бол, АНСХ, СДСХ, СХХ-ноос сонгуулийн өдрийн үйл ажиллагааны танилцуулгуудыг хийсэн юм.<sup>25</sup> Залуу сонгогчид сонгуулийн сонирхол буурч буй талаар АИХЭГ-ын САХ-ны маш олон ярилцагчид сонгогчдын боловсролын шинэлэг хөтөлбөрүүдийн хэрэгцээ шаардлага буйг онцолж байлаа. Хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэд хараат бус, нууцаар санал өгөх эрхийг баталгаажуулсан нь олон улсын жишиг, үүрэг амлалттай нийцдэг. Хуульд санал авах байр бүрд тэргэнцэртэй иргэдэд зориулсан санал өгөх бүхээг ядахдаа нэг байхыг шаарддаг. Мөн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд

<sup>21</sup> СЕХ-ны одоогийн 2020 онд томилогдсон бөгөөд хоёр гишүүн огцорсон тул 2024 оны 1 дүгээр сард нөхөн томилсон.

<sup>22</sup> ГХЯ-ны дэргэд гадаадад оршин суугаа иргэдийн санал авах тусдаа комисс байгуулж, 37 улсад суугаа дипломат төлөөлөгчийн газарт нийт 47 сонгуулийн хэсгийн хороо байгуулагдсан. Гадаадад суугаа сонгогчид зөвхөн пропорциональ өрсөлдөөнд санал өгсөн юм.

<sup>23</sup> Сонгууль зохион байгуулах албан хаагчдыг бүртгэх, цахим сургалт, сертификат олгох болон нэр дэвшигчид, иргэний ажиглагчдыг бүртгэхэд *e-election.mn* системийг ашиглав.

<sup>24</sup> СЕХ шийдвэрээ албажуулахын тулд ээлжит бус хуралдаан хийдэг бөгөөд, хуралдаан болж өнгөрсний дараа хэвлэлийн мэдээгээр олон нийтэд мэдээлдэг. АИХЭГ-ын САХ-ны ашиглагчид анхан шатны сонгуулийн хороодын хуралдааны дийлэнхийнх нь талаар огт мэдээлэл аваагүй бөгөөд, уригдсан тохиолдолд хуралдаан болохын өмнөхөн мэдээлэл авч байлаа.

<sup>25</sup> АНСХ энэ зорилгоор орон нутгийн телевиз, цахим мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллаж, бүсийн ИНБ-уудтай хамтран залуу, эмэгтэй сонгогчдод мэдээлэл түгээх ажлыг зохион байгуулсан. (Говь-Алтай, Өвөрхангай, Ховд, Увс, Дархан-Уул аймгийн сонгуулийн хороод).

өөрийн сонгосон сонгогчийн тусламж авах эрхтэй. Харааны бэрхшээлтэй иргэдэд хараат бус саналаа өгөх боломжоор хангаж, СЕХ Брайл үсэг бүхий саналын хуудасны хавтас, томруулдаг шилийг байршуулсан. Дохионы хэлмэрч ашигласан сонгогчдын боловсролын дүрс бичлэг олон нийтийн болон хувийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, телевиз, СЕХ-ны цахим хуудас, нийгмийн сүлжээгээр мөн тавигдсан юм. СЕХ-ны цахим хуудас харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан хувилбартай боловч, Цахим Контентын Хүртгэмжийн Удирдамж (ЦКХУ) бүрэн мөрдөхийн тулд цаашид сайжруулах хэрэгтэй байна.<sup>26</sup>

## VI. САНАЛ ӨГӨХ ТЕХНОЛОГИ

2012 оноос хойш, бүх санал авах байр электрон санал тоолох төхөөрөмжөөр (СТТ) тоноглогдсон.<sup>27</sup> СТТ сонгуулийн өдөр оффлайн горимд ажилладаг бөгөөд зөвхөн санал тоолж дууссаны дараа урьдчилсан үр дүнг СЕХ-нд дамжуулах үед энгийн болон хиймэл дагуулын интернэт сүлжээнд холбогддог.

Сонгуулийн зарим оролцогч талууд санал тоолох электрон төхөөрөмжид эргэлздэгээ АИХЭГ-ын САХ-нд илэрхийлсэн ч, тэд энэ болон өмнөх сонгуулиудад эдгээр санал тоолох машинаар дамжуулан албан ёсны үр дүнг хуурамчаар үйлдэж болох механизмыг тайлбарлаж чадаагүй буюу, тодорхой нотлох баримтыг дэлгэж чадаагүй юм. СТТ-ийн талаарх олон нийтийн ойлголт, ил тод байдлыг сайжруулахаар СЕХ сонгуулийн өдрийн өмнөхөн өрсөлдөгчид, иргэний нийгмийн төлөөлөл, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг оролцуулан төхөөрөмжийг туршиж үзүүлсэн. Оролцогч талууд өөрсдөө санал тоолох төхөөрөмжийг турших боломжоор хангагдаж, тус туршилт, шалгалтыг хэд хэдэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулав. Түүнчлэн, тус шалгалтыг улс даяар зарим сонгуулийн хэсгийн хороод сонгууль болохоос хоёр өдрийн өмнө зохион байгуулсан. Олон нийтийг оролцуулсан СТТ-ийг шалгах ажил СЕХ, болон СХХ-нд санамсаргүй сонгосон төхөөрөмжид туршилтын саналын хуудас ашиглахаар хязгаарлагдсан юм.

СЕХ пропорциональ, мажоритар өрсөлдөөн тус бүрд зориулсан 2 тусдаа саналын хуудас гаргасан. Санал авах байр бүрд саналын хуудсыг скандах, тоолох, хадгалах үүрэгтэй электрон төхөөрөмж байрлуулдаг. 1700-аас дээш тооны сонгогчтой санал авах байранд урт дараалал, сонгогчдыг хэт ачаалал үүсэхээс сэргийлж 2 төхөөрөмж байрлуулна. Санал тоолох төхөөрөмжид итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхийн тулд УИХСтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулж, бүх санал авах байранд машинаар тоолсон үр дүнг баталгаажуулж гар тооллого хийхээр тусгасан. Энэ аргыг 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар хэрэглэсэн бөгөөд тус сонгууль тусдаа хуулиар зохицуулагддаг. УИХСтХ-д төхөөрөмжөөр тоолсон дүн албан ёсны дүн байх тухай заасан боловч, гар тооллого хийх журам, болон гар тооллого, төхөөрөмжийн тооллогоос зөрсөн тохиолдолд хэрхэх талаар нарийн зохицуулалтыг тусгаагүй байна.

*Эрх зүйн болон үйл ажиллагааны тодорхойгүй байдал үүсэхээс сэргийлж, хяналтын тооллого зохион байгуулахад шаардлагатай алхам бүрийг тусгасан хяналтын тооллогын тодорхой журам боловсруулах ёстой. Түүнчлэн, төхөөрөмжөөр тоолсон дүн, гар тооллогын дүн хоорондоо зөрсөн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой зохицуулалт тусгах шаардлагатай.*

АИХЭГ өмнө нь зөвлөмж гаргаж байсныг үл харгалзан, санал тоолох төхөөрөмжийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, төхөөрөмжийн аюулгүй байдал, үнэн зөв ажиллагаатай холбоотой

<sup>26</sup> [ЦКХУ](#) нь интернэтийн олон улсын стандартын үндсэн байгууллага Ворлд Вайд Вэб Консорциумын Цахим Хүртгэмжийн Санаачилгаас хэвлүүлсэн цуврал удирдамжийн нэг юм.

<sup>27</sup> Тодруулбал, Доминион Вөүтинг Системсийн хөгжүүлсэн [ImageCast Precinct](#) оптик сканнерийн үйлдэлтэй.

эргэлзээг тайлах үүднээс засгийн газрын бус, бие даасан, гуравдагч этгээдээр санал тоолох төхөөрөмжийг баталгаажуулах зохицуулалтыг хуульд тусгаагүй байна. Хөндлөнгийн баталгаажуулалт хийх боломж хомс байгаа нь олон улсын тогтсон сайн туршлагатай харшилж байна.<sup>28</sup> Санал тоолох бүх төхөөрөмжийг үндсэндээ СЕХ-той хамтран ажилладаг төрийн байгууллагуудаас бүрдэх ажлын хэсэг шалгаж, баталгаажуулдаг.<sup>29</sup> Сонгуулийн өмнө болон дараа санал тоолох төхөөрөмжид хөндлөнгийн аудит хийгддэггүй бөгөөд, техникийн саатал, гар тооллогын зөрүүтэй тохиолдол зэргийг баримтжуулдаггүй байна.<sup>30</sup>

*Сонгуулийн санал тоолох технологид итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн тулд төхөөрөмж, программ хангамжид хөндлөнгийн баталгаажуулалт, аудит хийх боломжийг хуульд тодорхой тусгах шаардлагатай.*

## VII. СОНГОГЧИЙН БҮРТГЭЛ

Шүүхийн шийдвэрээр эрх зүйн чадамжгүй болсон, үйлдсэн гэмт хэргийн хүнд, хөнгөнөөс үл хамааран шоронд ял эдэлж буй иргэдээс бусад сонгуулийн өдөр буюу түүнээс өмнө 18 насанд хүрсэн иргэн бүр сонгох эрх эдэлнэ. Сонгох эрхийн эдгээр хязгаарлалтууд олон улсын өмнө хүлээсэн үүрэг АИХЭГ-ын өмнөх зөвлөмжүүдтэй харшилдаг.<sup>31</sup>

*Оюуны бэрхшээлтэй гэх үндэслэлээр сонгох эрхийг хязгаарласан заалтуудыг халж, шоронд ял эдэлж буй иргэдийн сонгох эрхийг бүрмөсөн хасаж буй асуудлын олон улсын өмнө хүлээсэн үүрэгтээ нийцүүлж шинэчлэх шаардлагатай.*

Сонгогчдын нэрийн жагсаалтыг Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас (УБЕГ) байнга шинэчилдэг үндэсний хүн амын өгөгдлийн сангаас гаргаж авдаг. Санал өгөх үед сонгогчдын цээж зураг, хурууны хээ зэрэг биеийн давхцахгүй өгөгдөл ашиглан сонгогчийг баталгаажуулна.<sup>32</sup> УИХСтХ-д сүүлд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр сонгогч давхар саналаа өгөхөөс сэргийлэх, өөр санал авах байранд очсон тохиолдолд зөв байршлыг зааж өгөх зорилгоор санал авах байранд ашиглах сонгогч таних төхөөрөмжүүд нь УБЕГ-ын сервертэй холбогдсон байх ёстой. Ерөнхийдөө, АИХЭГ-ын САХ-ны ярилцсан хүмүүс сонгогчдын нэрийн жагсаалт бүх сонгогчийг хамруулсан

<sup>28</sup> [Цахим санал хураалтын стандартын талаар гишүүн орнуудын сайд нарын зөвлөлөөс 2017 онд гаргасан зөвлөмжийн](#) 33 дугаар догол мөрд хяналт, баталгаажуулалтын зорилгоор цахим тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүдийг ил болгох ёстой талаар дурдсан. 37 дугаар догол мөрд “Цахим санал хураалтын системийг нэвтрүүлэхээс өмнө болон дараа зохих интервалаар, ялангуяа системд томоохон өөрчлөлт оруулсны дараа цахим сонгуулийн систем, сонгуулийн санал хураалтад нийцэж байгаа эсэхийг хараат бус, мэргэжлийн байгууллага мэдээллийн болон харилцаа холбооны технологийн бүрэлдэхүүнийг техникийн шаардлагын дагуу үнэлэх ёстой. Үүнд, албан ёсны баталгаажуулалтын гэрчилгээ, бусад зохих арга хэрэгсэл ашиглаж болно” гэж заажээ.

<sup>29</sup> Үүнд, СЕХ, Тагнуулын Ерөнхий Газар, Цахим хөгжил, Харилцаа холбооны яам хамаарна.

<sup>30</sup> [Цахим санал хураалтын стандартын талаар гишүүн орнуудын сайд нарын зөвлөлөөс 2017 онд гаргасан зөвлөмжийн](#) 39 дүгээр догол мөрд, “Цахим саналын систем аудитлагдах боломжтой байх ёстой. Аудитын тогтолцоо нь нээлттэй, иж бүрэн, боломжит асуудал, аюулыг идэвхтэй мэдээлдэг байх ёстой” гэж заасныг үзнэ үү.

<sup>31</sup> ЕАБХАБ-ын 1990 оны ЕАБХАБ-ын Копенхагены Баримт Бичгийн 7,3-т оролцогч улсуудыг “насанд хүрсэн иргэдэд бүх нийтийн, тэгш сонгох эрхийг хангахыг” уриалж, 24-р зүйлд, эрх, эрх чөлөөнд хязгаарлалт хийж байгаа бол “хуулийн зорилгод хатуу нийцэх ёстой” гэжээ. 2006 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын (ХБХЭТК) 12-р зүйлд хөгжлийн бэрхшээлтэй иргэд хуулийн өмнө ижил тэгш эрхтэйг хүлээн зөвшөөрөх тухай заасан байдаг. 29-р зүйлд, Улс орнууд “хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн эрхийг хүлээн зөвшөөрч, бусадтай адил тэгш эдлэх боломжоор хангахыг” шаарддаг. ХБХЭТК-ын 12-р зүйлийн нэг дэх хэсэгт 2022 онд өгсөн Ерөнхий санал, зөвлөмжийн 48-р догол мөрд “хүний шийдвэр гаргах чадамжид хөгжлийн бэрхшээлд нь үндэслэн саад болохыг зөвтгөх, сонгох, болон сонгогдох эрхээ хэрэгжүүлэхээс хасах үндэслэл болохгүй” гэжээ.

<sup>32</sup> Хурууны хээ нь таараагүй бол сонгогч санал өгөх эрхгүй. Гэвч, насжилттай холбоотойгоор хурууны хээ нь уншигдаагүй бол, сонгогч иргэний үнэмлэхээр баталгаажуулж санал өгч болно.



гэдэгт итгэж буйгаа илэрхийлсэн. Гэсэн хэдий ч, нэг хаягаас нөгөөд шилжсэн сонгогчдын шилжих хөдөлгөөний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл аймаг тус бүрээр гардаггүй, болон УБЕГ-ын мэдээллийн ил тод байдалд ерөнхийдөө эргэлзэж буй талаар АИХЭГ-ын САХ-ны ярилцсан зарим хүмүүс дурдсан юм.

УБЕГ 4 дүгээр сарын 1-ний өдөр сонгогчдын нэрийн жагсаалтыг баталгаажуулж, урьдчилсан байдлаар цахим хуудастаа байрлуулсан бөгөөд 6 дугаар сарын 25-ны өдөр 2,224,233 сонгогч буйг зарласан.<sup>33</sup> 2023 онд хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу сонгогчид өөрсдийн хаяг дээр бүртгэлтэй бүх сонгогчийг цахимаар шалгах боломжтой болсон. Түүнчлэн, сонгогчийн бүртгэлийн мэдээллийг 6 дугаар сарын 3-25-ны өдрүүдэд сонгуулийн хэсгийн хороонд баталгаажуулж, зөрүүтэй мэдээллийг санал хураахаас 14 хоногийн өмнө засуулах боломжтой. Хэд хэдэн сонгуульд өрсөлдөгчдийн хүсэлтэд үндэслэн, УБЕГ 6 дугаар сарын 8, 25-ны өдрүүдэд сонгуульд өрсөлдөж буй бүх намуудад сонгогчдын нэрийн жагсаалтын урьдчилсан болон эцсийн хувилбарыг электрон хэлбэрээр өгсөн юм.

АИХЭГ-ын САХ сонгогчдоос хаяг дээр нь үл мэдэгдэх иргэд бүртгэгдсэн тухай хэд хэдэн мэдээлэл хүлээн авсан.<sup>34</sup> УБЕГ хуулийн хугацаанд 136,000 иргэн өөрсдийн бүртгэлийн мэдээллээ баталгаажуулж, 8000 сонгогч буруу мэдээллийг залруулах хүсэлт илгээсний 82 хувийг хаяг дээр нь бүртгэгдсэн үл мэдэгдэх иргэнийг хасуулах хүсэлт байсан талаар мэдээлэв.<sup>35</sup> УБЕГ иргэд гадаад улс руу шилжсэн, эсвэл байршил нь тодорхойгүй байх тохиолдол их байдаг тул иргэн бүрд оршин суугаа хаягаа шинэчлэх шаардлагатай талаар холбогдох боломжгүй байдаг талаар АИХЭГ-ын САХ-нд тайлбарласан. Иргэдэд мэдээлэхгүйгээр УБЕГ оршин суугаа хаягаас нь хасах, дахин бүртгэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжгүй аж.

Сонгогчийн оршин суугаа хаягаас хамааран сонгогч аль нэг хэсгийн хороонд харьяалагдах бөгөөд сонгогч хаягийн бүртгэлээ санал хураах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө өөрчлөх боломжтой.<sup>36</sup> АИХЭГ-ын САХ-ны уулзсан зарим хүн өнгөрсөн 2 жилийн хугацаанд сонгуульд нэр дэвшиж буй зарим ажил олгогч өөрийн ажилчдаа дэвшиж буй тойрог руугаа шилжүүлж, саналыг нь авахын тулд тасралтгүй шахаж байсан талаар мэдээлэв. УБЕГ-аас өнгөрсөн саруудад 70,000 гаруй иргэний шилжих хөдөлгөөн бүртгэгдсэнээс дийлэнх нь Улаанбаатар хот дотроо, магадгүй сонгуулийн өөр тойргууд руу шилжсэн талаар АИХЭГ-ын САХ-нд мэдэгдсэн юм.<sup>37</sup> Хэд хэдэн улс төрийн нам сонгогчдын дахин бүртгэлийн тоон задаргааг авах хүсэлт гаргасан боловч УБЕГ хувийн мэдээллийг хамгаалах асуудалтай холбоотой тус мэдээллийг гаргаж өгөөгүй нь, ерөнхийдөө сонгогчдын бүртгэлийн ил тод байдлыг хязгаарлаж байна.

*Сонгогчдын нэрийн жагсаалтын ил тод байдал, сонгогчдын бүртгэлийн үнэн зөв байдалд итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн тулд Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар бүртгэлтэй холбоотой өгөгдлийг бүс бүсээр нь тоймлохоос илүүтэй, нутаг дэвгээр нь задлан ангилсан мэдээллийг нийтлэх эсэх талаар тунгаах нь зүйтэй.*

<sup>33</sup> Энэ удаагийн сонгуульд гадаадад оршин суугаа 13,095 сонгогч сонгуульд оролцохоор хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газарт бүртгүүлжээ.

<sup>34</sup> Нэг хаяг дээр хэд хэдэн хүн бүртгэгдсэн тохиолдлуудын дийлэнх нь нийслэл хотод байсан талаар мэдээлсэн.

<sup>35</sup> УБЕГ иргэнийг бүртгэлтэй хаягаас нь хасах тохиолдолд тухайн иргэн сонгогчдын жагсаалтаас хасагдах төдийгүй төрийн үйлчилгээ авч чадахгүй болох тул шалгалт хийх, мэдэгдэл өгөхийг журмаар шаарддаг байна.

<sup>36</sup> Сонгуулийн ажилтан, цагдаагийн албан хаагч, иргэний улсын бүртгэгч, мэдээллийн технологийн ажилтан гээд сонгуулийн үеэр ажиллах албан хаагчид сонгууль болохоос 14-өөс доошгүй өдрийн өмнө ажиллах санал авах байрандаа санал өгөх хүсэлт гаргаж болно.

<sup>37</sup> 2024 оны 1-р сарын 1-ний өдрөөс 4-р сарын 29-ний өдрийн хооронд нийслэлийн хэмжээнд 42570 хүн, нийслэлээс аймгууд руу 9420 хүн, аймгаас нийслэл рүү 11389 хүн, аймгаас аймгийн хооронд 6512 хүн хаягаа шилжүүлжээ.

АИХЭГ-ын САХ-ны уулзсан хэд хэдэн хүн зарим сонгогчид, ялангуяа уурхайн болон улирлын шинжтэй ажил эрхэлдэг сонгогчид сонгуулийн өдөр ажлын байраа орхин харьяалагдах санал авах байранд очиж санал өгөх боломжтой эсэх талаар санаа зовниж буйгаа илэрхийлсэн. Ажил олгогч ажилтнаа саналаа өгөх боломжоор хангах хуулийн үүрэгтэй боловч, бодит байдалд сонгогч өөрийн санал авах байранд хүрч очиход урт зам туулах, захим тохиолдолд эзгүй байхыг ажил нь зөвшөөрдөггүй гэх мэт бэрхшээл байдаг байна.<sup>38</sup> Сонгуулийн зарим оролцогч талууд СЕХ-нд тэдгээр сонгогчдыг санал өгөх боломжоор хангах, магадгүй тээврийн хэрэгсэл гаргах гэх мэт хүсэлтүүд тавьсан боловч, эдгээр хүсэлтүүд нь эрх зүйн үндэслэлгүй бөгөөд СЕХ сонгогчдыг тээвэрлэх ажил зохион байгуулаагүй.

## VIII. НАМЫН БОЛОН НЭР ДЭВШИГЧИЙН БҮРТГЭЛ

Сонгуулийн эрх бүхий 25 нас хүрсэн сонгогч нэр дэвшиж болно. Зохисгүй зарим хязгаарлалтыг 2023 онд сонгуулийн хуулиас хассан ч нэр дэвших эрхийг хязгаарласан заалтууд байсаар байна. Шүүхээр тогтоосон өр, хугацаа хэтэрсэн татварын өр, эсвэл 51-ээс дээш хувийг нь эзэмшдэг компани хугацаа хэтэрсэн өр төлбөртэй бол нэр дэвших боломжгүй. Ял эдэлж буй болон авлига, албан тушаалын хэрэг үйлдэж байсан хүн мөн нэр дэвших боломжгүй. Түүнчлэн, төрийн болон орон нутгийн өмчит болон оролцоот хуулийн этгээдийн удирдлагын албан тушаал эрхэлж буй хүмүүс нэр дэвших бол сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө албан тушаалаасаа огцорсон байх ёстой. Эдгээр хязгаарлалтууд сонгогдох эрхийн талаар олон улсын жишиг, ЕАБХАБ-ын үүрэг амлалттай нийцэхгүй байна.<sup>39</sup>

*Өмнө нь зөвлөмж гаргаж байсанчлан, хугацаа хэтэрсэн өр, татварын өр, ял шийтгүүлж байсан гэх үндэслэлээр эрхийг хязгаарласан заалтыг хүчингүй болгох ёстой. Нэр дэвших хүсэлтэй төрийн албан хаагч, нэр дэвшигчийг бүртгэлийн хугацаа эхлэх хүртэл албан тушаалаасаа чөлөөлөгдөх шаардлагагүй.*

Албан ёсоор бүртгүүлэхийн тулд, улс төрийн нам 801-ээс багагүй үүсгэн байгуулагчийн дэмжлэг авах, мөн намын дүрэм, эд хөрөнгийн жагсаалт зэрэг баримт бичгийн хамт Улсын Дээд Шүүхэд бүртгүүлэхийг хуульд шаарддаг. Гэсэн хэдий ч, Улсын Дээд Шүүх яг 801-тэй тэнцүү тооны гишүүн байх тохиолдолд хүсэлтийг хүлээж авах бодлого баримталдаг талаар АИХЭГ-ын САХ-нд мэдээлсэн.<sup>40</sup> Энэ туршлага нь хуулийг эсрэг тайлбарлаж буй бөгөөд эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарлаж буй үйлдэл юм.

Улс төрийн нам, эсвэл сонгуульд оролцох сонирхлоо сонгуулийн өдрөөс 60-аас доошгүй өдрийн өмнө СЕХ-нд мэдэгдэх ёстой. Түүнчлэн, бүх өрсөлдөгчид сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай, санхүүгийн санал нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуультай нийцэж буй

<sup>38</sup> Биелүүлээгүй тохиолдолд иргэнийг 10000 төгрөг (ойролцоогоор 2.7 евро) хуулийн этгээдийг 100,000 төгрөгөөр (ойролцоогоор 27.4 евро) тус тус торгоно.

<sup>39</sup> ИБУТЭОУП-ын 25-р зүйлд НҮБ-ын Хүний Эрхийн Комиссоос гаргасан ерөнхий санал, зөвлөмжийн 15-р догол мөрд “Сонгуульд нэр дэвших боломжтой хүмүүсийг боловсрол, оршин суугаа газар, удам угсаа, улс төрийн харьяаллаар нь ялгаварлан гадуурхаж, эсвэл ямар нэг шалтгаангүйгээр сонгуульд өрсөлдөхөөс хасаж болохгүй” гэжээ. [1990 оны ЕАБХАБ-ын Копенхагены Баримт бичгийн](#) 7.5-р догол мөрд оролцогч улс орнууд иргэдийнхээ улс төрийн болон нийтийн албан тушаал хаших эрхийг хүндэтгэх ёстой гэжээ. Түүнчлэн, 24-р догол мөрд эрх, эрх чөлөөнд тавьж буй аливаа хязгаарлалт нь “хуулийн зорилготой хатуу нийцэж байх ёстой” гэжээ.

<sup>40</sup> Хэрэв жагсаалтад 801-ээс илүү тооны нэр байвал, багасгахаар буцаагдана. Түүнчлэн, бүх хүний мэдээллийг шалгах бөгөөд, нэг л зөрүү гарвал засахаар буцаагддаг байна.

эсэхийг шалгуулахаар Үндэсний Аудитын Газар (ҮАГ) илгээх ёстой.<sup>41</sup> Эдгээр хязгаарлалтууд нь олон улсын жишиг, сонгуулийн сайн туршлагатай нийцдэггүй.<sup>42</sup>

*Улс төрийн олон ургалч байдалд шаардлагагүй хязгаарлалт тавилгүй, олон улсын жишигт нийцүүлэхийн тулд өрсөлдөгчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт бодлогод суурилсан шалгуур тавих нь зохимжгүй тул дахин тунгааж үзэх шаардлагатай.*

Сонгуульд оролцохоор бүртгүүлсэн улс төрийн нам, эвслүүд 5 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн 7 хоногийн турш нэр дэвших ажиллагааг явуулна. Бие даан нэр дэвшигчид энэ хугацаанд нэр дэвшүүлэх эрхтэй бөгөөд нэр дэвшигчээр бүртгэгдэхийн тулд яг 801-тэй тэнцүү тооны дэмжигчдийн гарын үсэг цуглуулна. Улс төрийн намаас нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байх бөгөөд, пропорциональ намын жагсаалтад хүйсийн харьцаа сөөлжсөн байх хуулийн заалттай.<sup>43</sup> Пропорциональ жагсаалтад жендэрийн тэнцвэртэй байдлыг хангасан нь ерөнхийдөө эерэг өөрчлөлт мөн боловч улс төрийн намууд мажоритар өрсөлдөөнд илүү олон эрэгтэйчүүдийг нэр дэвших боломж олгож байна. АН, МАН, Эх орон намаас бусад бүх өрсөлдөгчид хуульд заасан жендэрийн квотоос илүү тооны эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлжээ.

Улс төрийн нам, эвслүүд тухайн тойргийн мандаттай тэнцүү тооны хүртэлх хүнийг нэр дэвшүүлэх боломжтой. Нэг нэр дэвшигч мажоритар сонгуулийн тойрогт, эсвэл пропорциональ намын жагсаалтын аль нэгд нь нэр дэвшиж болно. 6 дугаар сарын 10-ны өдөр СЕХ-ноос улс төрийн 19 нам, 2 эвсэл, нийт 1336 нэр дэвшигч (817 эрэгтэй, 519 эмэгтэй) мажоритар болон пропорциональ өрсөлдөөнд бүртгэгдсэн талаар мэдээлсэн. Бие даан нэр дэвшигч 42 хүн мажоритар өрсөлдөөнд бүртгэгджээ. 11 нэр дэвшигч янз бүрийн шалтгаанаар бүртгэлийн шалгуурыг хангаагүй тул бүртгэхээс татгалзжээ.<sup>44</sup> Үүнээс 5 нь шүүхэд хандаж, шүүхийн шийдвэрээр нэр дэвшигчээр бүртгэгдсэн. СЕХ нэр дэвшигчдийг бүртгэхдээ хуулийг баримталж, шаардлагатай материалаа засах хугацааг олгож байсан хэдий ч нэр дэвшихтэй холбоотой хэд хэдэн хязгаарлалт, хэт их тавигдах шаардлага зэрэг нь сонгогдох эрхийг бүх нийтэд эдлүүлэхтэй холбоотой асуулт төрүүлж байна.

Эрх зүйн орчинд саяхан хийгдсэн өөрчлөлтүүд улс төрийн нам хөгжлийн бэрхшээлтэй иргэн нэр дэвшүүлбэл санхүүгийн хөшүүрэг олгох байдлаар тэднийг дэмжжээ. Монголын Тэргэнцэртэй Иргэдийн Үндэсний Холбооны хэлснээр, мажоритар өрсөлдөөнд 1, пропорциональ өрсөлдөөнд 3, нийт хөгжлийн бэрхшээлтэй 4 иргэн нэр дэвшигчээр бүртгэгджээ.

<sup>41</sup> Хөгжлийн бодлогыг Засгийн газар боловсруулж, УИХ-д өргөн барина. Засгийн газрын урт хугацааны бодлого [Алсан хараа - 2050](#) хөтөлбөр 2020 оны 5 дугаар сард батлагдсан. ҮАГ сонгуулийн өдрөөс 60-аас доошгүй өдрийн өмнө өрсөлдөгч тус бүрд хөтөлбөр нь нийцэж буй эсэх талаар мэдэгдэл гаргаж, СЕХ-нд хүргүүлнэ.

<sup>42</sup> Article 19.1 and 19.2 of the [1996 оны ИБУТЭОУП-ын](#) 19.1-р зүйлд “Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй”, 19.2-р зүйлд “Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэ эрхэд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан, амаар, бичгээр эсвэл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсвэл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана” гэжээ. [2020 оны АИХЭГ, Венецийн Комиссын Улс төрийн намын эрх зүйн зохицуулалтын хамтарсан удирдамжийн](#), 43-р зүйлд “Улс төрийн нам, түүний гишүүдийн баримталж буй байр суурь төрийн бодлогод нийцэж байгаа эсэх, хууль эрх зүй, нийгмийн өөрчлөлтийг сурталчилж буй эсэх, эсвэл олонд танигдаагүй, эсвэл зарим бүлгүүдийг дайрч давшилсан байр суурьтай эсэхээс үл хамааран улс төрийн болон төрийн үйл хэргийн талаарх хэлэлцүүлэгт оролцох эрхтэй байх явдал нэн чухал” гэснийг үзнэ үү.

<sup>43</sup> Хуульд мөн 2028 оны сонгуулиас нэр дэвшигчдийн хүйсийн квотыг аль нэг хүйсийн төлөөлөл 40-өөс доошгүй хувь байхаар тусгажээ.

<sup>44</sup> Гурван нэр дэвшигч хугацаа хэтэрсэн татварын өртэй, гурван нэр дэвшигч бичиг баримт бүрэн бус, дөрвөн нэр дэвшигч нэр дэвшүүлснээс өөр намын гишүүнчлэлтэй, нэг нэр дэвшигч 2024 оны 1-р сарын 1-ний өдрөөс өмнө албан тушаалаас чөлөөлөгдөөгүй.



## IX. СОНГУУЛИЙН КАМПАНИТ АЖИЛ

Сонгуулийн сурталчилгаа албан ёсоор 6 дугаар сарын 10-ны өдөр буюу сонгуулийн өдрөөс 18 хоногийн өмнө эхэлж, 24 цагийн өмнө дууссан. Нэр дэвшихээр горилогчид албан ёсны сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө сурталчилгаа явуулахыг хуулиар хориглодог. Гэсэн хэдий ч, одоогийн УИХ-ын гишүүд дахин нэр дэвшихийг зорьж буй, нэр дэвшигчээр бүртгүүлэх үйл явц эхэлсэн эсэхээс үл хамааран сонгогдсон төлөөлөгчийн хувиар өөрсдийгөө сурталчилж болно. АИХЭГ-ын САХ-ны уулзсан маш олон хүн хуулиар зөвшөөрсөн тул одоогийн УИХ-ын гишүүд, төрийн өндөр албан тушаалтнууд сонгууль болохоос өмнө хэдэн сарын турш идэвхтэй кампанит ажил явуулж байсан талаар мэдэгдсэн юм. Ерөнхийдөө маш богино сурталчилгааны хугацаанд, шинээр байгуулагдсан том хэмжээтэй сонгуулийн тойргуудад кампанит ажил явуулахад бэхэжсэн улс төрийн намуудад ихээхэн давуу тал үүсгэж байв. Сонгуулийн хэсэг бүрд ашиглаж болох тээврийн хэрэгсэл, ухуулах байр, ухуулагчдын тоо зэргийг хязгаарласан бөгөөд сонгуулийн кампанит ажлыг хуульд хэт зохицуулсан шинжтэй байна. Мөн сонгууль өгөхгүй байхыг уриалах, сонгуулийн жил эхэлснээс сонгууль дуустал улс төрийн чансаа тогтоох олон нийтийн санаа бодлын судалгаа нийтлэхийг хуулиар хориглодог.

*Сонгуулийн кампанит ажил зохион байгуулах эрх зүйн орчин хэт хязгаарласан байдлыг бууруулах, сонгуулийн албан ёсны сурталчилгааны хугацаа, түүнээс өмнөх цаг үед бүх өрсөлдөгчид сурталчилгаа явуулах ижил тэгш нөхцөлөөр хангаж хуульд өөрчлөлт оруулах нь зүйтэй.*

Ерөнхийдөө өрсөлдөгчид чөлөөтэй, хөндлөнгийн оролцоогүйгээр кампанит ажил явуулсан хэдий ч, кампанит ажил тоглох тэгш бололцоогоор дутагдаж байв.<sup>45</sup> Ерөнхийдөө кампанит ажил нам гүм өрнөсөн хэдий ч, 6 дугаар сарын 15-ны өдөр МАН-ын нэр дэвшигч, Батлан хамгаалахын сайд Гүрсэдийн Сайханбаярын сонгуулийн ухуулагч Ардчилсан намын сумын намын хорооны даргатай муудсанаас амиа алдсан харамсалтай хэрэг гарлаа. АН тус аллагыг улс төрийн сэдэлтэй хэмээн буруутгаж, Ерөнхий сайд, Батлан хамгаалахын сайд нарыг огцрохыг шаардсан.<sup>46</sup> 6 дугаар сарын 25-ны өдөр Үндэсний эвслийн төв байранд “тролл арми” ажиллуулж, хувь хүмүүс сонгогчдод нөлөөлөхийн тулд улс төрийн өрсөлдөгчдийн талаар төлбөртэй пост, коммент нийтлэх зэрэг хууль бус сурталчилгааны ажил явуулж байна гэх гомдлын дагуу цагдаагийн байгууллага нэгжлэг хийв.<sup>47</sup>

УИХ-д суудалтай намууд аймгийн төвүүдээр томоохон кампанит ажил явуулж, улс даяар, ялангуяа зарим бүс нутагт айлын хаалга тогших кампанит ажил өрнүүллээ.<sup>48</sup> Жижиг улс төрийн намууд сурталчилгаа хийхдээ нийгмийн сүлжээнд илүү анхаарч цомхон кампанит ажил явуулав. Өрсөлдөгчид харилцан биесээ авлигад буруутгасан төдийгүй, эдийн засгийн хөгжил, дэд бүтэц, хүрээлэн буй орчин зэрэг томоохон сэдвүүдийг ч сонгуулийн үеэр багагүй ярьсан. МАН саяхан

<sup>45</sup> АИХЭГ-ын САХ-нд АН-ын өгсөн мэдээллээр 6-р сарын 2-ны өдөр тус намын пи-арын ажилтнуудыг саатуулжээ. 6-р сарын 18-ны өдөр Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн АН сонгогчид, ухуулагчдынхаа аюулгүй байдлыг хангах үүднээс кампанит ажлын арга хэмжээнүүдээ цуцалжээ.

<sup>46</sup> Ерөнхий сайд нэн даруй АН-ын даргатай уулзаж эмгэнэл илэрхийлсэн. Мөн, МАН нэр дэвшигч Сайханбаярыг нэр дэвшигчээс татуулах хүсэлтийг СЕХ-нд хүргүүлсэн боловч, нэр дэвшигчээс татах албан ёсны механизм үгүй тул СЕХ хүсэлтийг хүлээж авахаас татгалзжээ.

<sup>47</sup> 6-р сарын 25-ны өдөр [www.mpp.gov.mn](https://www.mpp.gov.mn) цахим хуудасны сэтгүүлч Үндэсний Эвслийн төв байранд нэвтэрч, лайв видео хийж тус эвсэл Хятад иргэдийг хөлслөн “тролл арми” ажиллуулж байна хэмээн буруутган цагдаа дуудав. Үүний дараа СЕХ-ноос Цагдаагийн Ерөнхий Газарт хэргийн газар хөдөлшгүй нотлох баримт үгүй бол СЕХ-ны зөвшөөрөлгүйгээр нэгжлэг хийх хориотой талаар албан бичиг илгээжээ. Цагдаагийн байгууллага бүртгэгдээгүй, нийгмийн сүлжээний хуурамч хаягууд сонгуулийн үйл ажиллагаа явуулж байсан гэж мэдээлсэн бөгөөд 148 хүний ердөө 2 нь л СЕХ-нд бүртгэлтэй гэжээ.

<sup>48</sup> АИХЭГ-ын САХ сонгуулийн сурталчилгааны 50 арга хэмжээ ажигласнаас 31-д нь эмэгтэй илтгэгч оролцуулсан байна. Эдгээр арга хэмжээний 46 нь хөдөлгөөний бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байсан бөгөөд хэдийгээр хуулиар шаарддаг боловч, ердөө нэг нь дохионы хэлмэрчтэй байсан юм.

танилцуулсан засгийн газрын хөтөлбөрүүд, тэдгээрийн амжилтыг онцолсон бол, АН үндсэндээ эрх баригч намын үр ашиггүй засаглалыг шүүмжилж байв. ХҮН нам, Үндэсний эвслийн хамтаар АН нийгмийн халамжийн зардлыг хязгаарлах, илүү либерал, зах зээлийн эдийн засгийг сурталчлахыг уриалж байлаа.

АИХЭГ-ын САХ-ны хэд хэдэн ярилцагч бараа бүтээгдэхүүн, бэлэн мөнгө амлах замаар сонгогчдын саналыг худалдаж авч байгаа зөрчлийн талаар мэдээлсэн.<sup>49</sup> Сонгогчдын саналыг худалдаж авч буй талаар ялангуяа сөрөг хүчний төлөөлөл дуугарсан бөгөөд гол төлөв МАН-ыг буруутгаж байсан юм.

Нэр дэвшигчийн албан тушаалынх нь болон нэр дэвшигчийнх нь үүргийг тусгаарласан шаардлага үгүй, мөн албан тушаалтан төрийн нөөцийг сонгуулийн кампанит ажилд ашиглахаас урьдчилан сэргийлсэн хангалттай зохицуулалт хуульд тусгагдаагүй байна.<sup>50</sup> Хотын дарга, засаг дарга нар гэх мэт нийтийн албан тушаалтнууд улс даяар идэвхтэй кампанит ажил өрнүүлж байв.<sup>51</sup> Сонгууль болохоос өмнө засгийн газар цалин нэмэх, нийгмийн халамжийг нэмэгдүүлэх, нэг удаагийн ногдол ашиг олгох зэрэг хөтөлбөр хэрэгжүүлсэн бөгөөд, эдгээрийг төрийн албан хаагчид сурталчилж, МАН-ын кампанит ажилд ашиглагдаж байсан юм.<sup>52</sup> Эдгээр туршлага нь нам, төрийн заагийг бүдгэрүүлж, эрх баригч намд хэт давуу тал олгож буй нь ЕАБХАБ-ын үүрэг амлалттай зөрчилдөж байна.<sup>53</sup>

АИХЭГ-ын САХ-ны ярилцсан хүмүүс төрийн болон нийтийн албан хаагчдыг эрх баригч намын өмнөөс сонгуулийн кампанит ажилд туслах, зохион байгуулах, кампанит ажлын арга хэмжээнд оролцохыг шаардах зэрэг дарамтууд гарсан талаар мэдээлсэн.<sup>54</sup> Энэ нь сонгогчид ямар нэг

<sup>49</sup> АИХЭГ-ын САХ энэ төрлийн мэдэгдэл Дорнод, Ховд, Орхон, Өмнөговь, Улаанбаатар, Завханд гарсан талаар мэдээлэл авсан.

<sup>50</sup> Төрийн албаны тухай хуульд төрийн захиргааны болон төрийн тусгай албан хаагчид улс төрийн намын үйл ажиллагаанд оролцохгүй байхыг шаарддаг. Монгол Улсын Төрийн Албаны Зөвлөлөөс 6-р сарын 10-ны өдөр сонгуультай холбоотой баримтлах ёс зүйн дүрмийг баталж, төрийн албан хаагчдыг улс төрийн үйл ажиллагаанд оролцохгүй байх, төвийг сахих, доод албан тушаалтнаа улс төрийн үйл ажиллагаанд оруулахгүй байхыг уриалсан.

<sup>51</sup> АИХЭГ-ын САХ-ны ажигласнаар Өмнөговь, Өвөрхангай, Улаанбаатар, Завханд МАН-ын харьяалалтай аймаг, сумын засаг дарга нар, Улаанбаатарт АН-ын харьяалалтай засаг дарга нар сонгуулийн сурталчилгаанд идэвхтэй оролцжээ.

<sup>52</sup> 1-р сард Эрдэнэс Таван Толгой төрийн өмчит хувьцаат компани 2012 оноос хойш төрсөн 893432 хүүхдэд хувьцаа олгожээ. 3-р сарын 1-ний өдрөөс Улаанбаатар хотын нийтийн тээврийн жолооч нарын цалинг нэмэгдүүлсэн. 2024 оны 3-р сарын 20-ны өдөр, тэтгэврийг 100000 төгрөгөөр (ойролцоогоор 27 евро) 2024 оны 3-р сарын 27-ны өдөр төрийн албан хаагчдын цалинг [нэмэгдүүлэв](#). 4-р сарын 19-ний өдөр УИХ стратегийн ач холбогдолтой уул уурхайн ордоос олох орлогын 34 хувийг төвлөрүүлэх Үндэсний Баялгийн Сангийн тухай хуулийг нэн яаралтай горимоор баталсан. 2024 оны 4-р сарын 24-ний өдөр Засгийн газар малчин өрхийг дэмжихэд зориулж 5 их наяд (1,4 тэрбум евро) төгрөгийн зээлийн хөтөлбөр [танилцуулсан](#) нь, улсын төсөвт урьдчилан тусаагүй төсвийн зардал байсан юм. Тохижилт үйлчилгээний компанийн ажилчдын цалинг 6-р сарын 1-ний өдрөөс нэмэгдүүлэх гэх мэт зардлыг Улаанбаатар хотын төсөвт 2024 онд тодотгол хийж суулгав.

<sup>53</sup> [1990 оны ЕАБХАБ-ын Копенхагены Баримт Бичгийн 5.4 дэх догол мөрд](#) “төр, улс төрийн намыг тодорхой зааглах” тухай заасан. Мөн [2016 оны ЕАБХАБ, Венецийн Комисстой хамтран гаргасан Сонгуулийн үйл явцад захиргааны нөөцийг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах удирдамжийн П.В.1.1. догол мөрд](#) “нийтийн албан тушаалтнууд албан тушаалаа ашиглан сонгуулийн сурталчилгааны зорилгоор олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах, шударга бусаар өөртөө давуу тал үүсгэхийг хориглох механизмыг хуулиар тодорхой зохицуулах ёстой” гэжээ.

<sup>54</sup> Төрийн албан хаагчдыг дарамталж, ажлын цагаар болж буй МАН-ын сурталчилгааны арга хэмжээнд төрийн албан хаагчдыг оролцохыг шаардаж буй талаар хэд хэдэн мэдээлэл Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Улаанбаатар, Завханд буй АИХЭГ-ын САХ-ны ажиглагчдад ирсэн.

дарамт шахалтгүйгээр, чөлөөтэй сонголт хийхэд нөлөөлж буй ихээхэн талаар зовнил төрүүлж байна.<sup>55</sup>

*Хуульд захиргааны нөөц ашиглах, төрийн албан хаагчдад кампанит ажилтай холбоотой дарамт үзүүлэх зэргийг тодорхойлж, хориглох, мөн төрийн албан хаагчдын албан үүрэг, сурталчилгааны үйл ажиллагааг тодорхой зааж, зааглах ёстой. Эрх мэдэлтнүүд үүнтэй холбоотой аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, арилгах талаар идэвх санаачилгатай арга хэмжээ авах ёстой.*

Дийлэнх улс төрийн намууд кампанит ажлынхаа үлэмж хэсгийг Фейсбүүк ашиглан явуулж буй талаар мэдэгдсэн. Цахим сурталчилгааг зөвхөн АНСХ-нд бүртгэгдсэн цахим хуудас, нийгмийн сүлжээний хаягаар явуулахаар хязгаарлажээ. Гэсэн хэдий ч, сонгуулийн кампанит ажлыг зөвхөн бүртгэгдсэн хүмүүсээр хязгаарлах нь улс төрийн мэтгэлцээнийг хумьж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах үр дагавартай буй нь олон улсын стандартад нийцэхгүй байна.<sup>56</sup> Нийгмийн сүлжээнд нэр дэвшигчийг гүтгэх, гутаан доромжлох, худал мэдээлэл түгээх нь хуулиар хориотой. УИХСтХ-д Харилцаа Холбооны Зохицуулах Хороо (ХХЗХ) бусад төрийн байгууллагын хамт цахим сурталчилгаанд хяналт, мониторинг хийх үүрэгтэй. Гэвч, ХХЗХ гагцхүү цагдаагийн байгууллагаас ирсэн гомдол, мэдээлэлд үндэслэн хариу арга хэмжээ авч байсан нь цахим сурталчилгааны агуулгад үр дүнтэй мониторинг хийх арга хэрэгсэл биш.<sup>57</sup>

Улс төрийн өрсөлдөгчид кампанит ажлын үйл явдлыг идэвхтэй хуваалцаж, хэвлэлийн бага хурал шууд дамжуулж, өөрсдийн Фейсбүүк хуудаснаа нэр дэвшигчдээ сурталчилж байлаа.<sup>58</sup> Ерөнхийдөө, нийтлэгдсэн контентуудын өнгө аяс төвийг сахисан, эдийн засаг, бүс нутгийн хөгжил, нийгмийн асуудлуудад төвлөрсөн байв. АН, Үндэсний эвсэл, МАН хамгийн идэвхтэй контентууд нийтэлж, хамгийн их хүнд хүрсэн.<sup>59</sup> Сонгуулийн кампанит ажлын үеэр бүртгэгдсэн бүх цахим хаягаар нийтлэгдсэн контентын өнгө аяс үндсэндээ төвийг сахисан шинжтэй байлаа. АИХЭГ-ын САХ-ны уулзсан сөрөг хүчний хэд хэдэн намууд Фейсбүүкт зохион байгуулалттай өрнүүлсэн кампанит ажил нь худал мэдээлэл дамжуулах замаар тэдний нэр хүндэд халдаж байсан хэмээн мэдэгдсэн юм.

<sup>55</sup> [1990 оны ЕАБХАБ-ын Копенхагены Баримт Бичгийн 7.7](#) догол мөрд сонгогчид сонгуулийн өдөр чөлөөтэй, хүчирхийлэл, дарамт, сүрдүүлгээс ангид саналаа өгөх боломжоор хангагдах ёстой талаар заасан. Мөн, [2020 оны АИХЭГ, Венецийн Комиссын Улс төрийн намын эрх зүйн зохицуулалтын хамтарсан удирдамжийн 252-254-р догол мөрийг](#) үзнэ үү.

<sup>56</sup> Хуульд нэр дэвшигч, шадар туслах, сонгуулийн менежер, ухуулагч нар л сурталчилгаа явуулах эрхтэй байхаар заасан. [ИБУТЭОУП-ын 19-р зүйлд](#), 2011 онд НҮБ-ын Хүний эрхийн хорооноос өгсөн [34-р ерөнхий дүгнэлтийн 20-р догол мөрд](#) “Иргэд, нэр дэвшигчид, сонгогдсон төлөөлөгчдийн хооронд олон нийт, улс төрийн асуудлын талаарх мэдээлэл, санаа бодлыг чөлөөтэй дамжуулах нь нэн чухал” гэсэн байдаг. Мөн 37-р догол мөрд, “Хорооноос айл айлын хаалга тогшиж сурталчилгаа хийх, сонгуулийн үеэр тараах сурталчилгааны материалын тоо, төрлийг хязгаарлах, олон улсын хэвлэл мэдээлэл, улс төрийн шинжилгээтэй нэвтрүүлэг, сөрөг хүчний улс төрчид хэвлэлд хандах зэргийг хязгаарлах нь улс төрийн мэтгэлцээнийг хязгаарлаж буй хэрэг” гэжээ.

<sup>57</sup> Сонгуулийн хууль зөрчсөн тохиолдолд цагдаа, тагнуулын байгууллагын зөвлөмж дээр үндэслэн ХХЗХ сонгуулийн үр дүн бүрэн гарч дуустал тухайн контентыг устгах, хязгаарлах хүсэлт гаргах боловч, нийгмийн сүлжээний платформ нь устгах, цуцлах эсэхийг шийднэ. ҮАГ нийгмийн сүлжээнд зарцуулж буй зардлыг хянаж, шалгадаггүй.

<sup>58</sup> 5-р сарын 29-ний өдрөөс эхлэн сонгуулийн албан ёсны сурталчилгааны хугацаа эхэлтэл АИХЭГ-ын САХ улс төрийн нам, эвсэл, улс төрчид болон бусад оролцогч талуудын Фейсбүүкийн 25 хаягийг дагасан. Албан ёсны сурталчилгааны хугацаанд нийтдээ улс төрийн нам, эвслийн 9, нэр дэвшигчид, улс төртэй холбоотой 21 нийтдээ 30 Фейсбүүк аккаунт дагаж мониторинг хийсэн.

<sup>59</sup> Албан ёсны сурталчилгааны хугацаанд нам эвслээс АН хамгийн их буюу 323, МАН (304), Үндэсний эвсэл (287) пост нийтэлжээ. Улс төрийн нам, эвслийн постууд хүмүүст хэр хэмжээнд хүрсэн талаар Үндэсний эвсэл хамгийн олон (339,709) хүнд хүрч, дараа нь МАН (175,097), АН (108,094), болон ХҮН нам (106,988) удаалав. Ерөнхийдөө бичлэг болон текст бүхий пост хамгийн их (43 хувь), дараа нь зөвхөн текст бүхий пост (30 хувь), харин зураг болон текст бүхий пост (26 хувь) арай бага байв.

АН, ХҮН нам, Иргэдийн Оролцооны Нэгдэл нам гэх мэт хэт хэдэн улс төрийн нам улс төрд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхийг уриалав. Эмэгтэй нэр дэвшигчид улс даяар идэвхтэй кампанит ажил өрнүүлж байсан хэдий ч, эмэгтэйчүүдэд чиглэсэн улс төрийн мессеж бараг байхгүй, сонгуулийн кампанит ажилд эрэгтэйчүүд давамгайлж байсан юм.<sup>60</sup>

## Х. КАМПАНИТ АЖЛЫН САНХҮҮЖИЛТ

Сонгуулийн сурталчилгааг иргэн, хуулийн этгээдээс авсан хандив болон нам, нэр дэвшигчид өөрсдийн хөрөнгөөр санхүүжүүлэх боломжтой. Бүх гүйлгээг ҮАГ-т бүртгэлтэй банкны дансаар хийх ёстой.

Иргэнээс өгөх хандивын хэмжээ 10 сая төгрөгөөр (2,750 орчим евро), хуулийн этгээдийн хувьд 30 сая төгрөгөөр (8.250 орчим евро) хязгаарлагдана. Нэг сая төгрөгөөс (275 орчим евро) дээш хандив өгсөн иргэний нэр, 2 сая төгрөгөөс (550 орчим евро) дээш хандив өгсөн хуулийн этгээдийн нэрийг ҮАГ нийтлэх үүрэгтэй. Мөнгөн бус хандивын үнэлгээг зах зээлийн дундаж ханшийг үндэслэн тогтоох бөгөөд уг үнэлгээ нь иргэн болох хуулийн этгээдээс өгөх хандивын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна. Хандив өгөхийг хориглосон этгээдийг хуульд мөн жагсаан тодорхойлжээ.<sup>61</sup> Хандив өгөхийг хориглосон этгээдээс хандив авсан тохиолдолд нэр дэвшигчийн бүртгэлийг хүчингүй болгох үндэслэл болдог. Гэсэн хэдий ч, энэ арга хэмжээн сонгуулийн өдрөөс өмнө авах боломжтой тул зөрчил үүссэн даруйд илрүүлээгүй л бол үр нөлөөг бууруулдаг талтай.

ҮАГ нь сонгуулийн сурталчилгааны санхүүжилтийг хянадаг ба сонгуулийн тойргийн хэмжээ, байршил, түүнчлэн өрхийн болон сонгогчдын тоог харгалзан СЕХ-ноос баталсан аргачлалаар сонгуулийн сурталчилгааны зардлын дээд хэмжээг тогтоодог. Энэ удаагийн сонгуулиар нам болон эвсэл нь 6,4 тэрбум төгрөг (1.7 сая орчим евро) зарцуулах боломжтой байна. Харин нэр дэвшигчид сонгуулийн тойргоос хамаарч 0.9-1.5 тэрбум төгрөг (244,000-407,000 орчим евро) зарцуулах боломжтой. АИХЭГ-ын САХ-ны уулзаж ярилцсан хэд хэдэн хүн зардлын дээд хэмжээ хэт өндөр байгаа нь харьцангуй илүү нөөцтэй, хэдийнээ бэхэжсэн УИХ-д суудалтай улс төрийн намуудад давуу тал олгож байна гэсэн юм. УИХСтХ-аар ҮАГ-т сонгуулийн сурталчилгааны санхүүжилт болон зарцуулалтад дангаараа болон бусад байгууллагуудтай хамтран хяналт тавих эрхийг олгосон хэдий ч, ҮАГ нь баримт мэдээлэл хайн илрүүлэх, мониторингийн үйл ажиллагаа явуулаагүй нь сонгуулийн сайн туршлагатай нийцээгүй.<sup>62</sup> УИХСтХ-ийн сүүлд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр СЕХ-нд бүртгэгдсэн Иргэний Нийгмийн Байгууллагууд (ИНБ) сонгуулийн зардлын тайлан, бусад баримт бичгийг нягтлах, хараат бус мониторинг хийх эрхтэй болсон.<sup>63</sup> Гэсэн хэдий ч, ҮАГ-аас үр дүнтэй хяналтын үйл ажиллагаа явуулдаггүй нь хуулийн тус зохицуулалтын үр нөлөө, улс төрийн намуудын хариуцлагатай байдлыг бууруулж байна.<sup>64</sup>

<sup>60</sup> АИХЭГ-ын САХ-ны ажигласан сонгуулийн сурталчилгааны 50 арга хэмжээг ажигласнаас 31 арга хэмжээнд 57 эмэгтэй илтгэгч оролцсон бол харьцуулахад эдгээр арга хэмжээнд нийт 200 эрэгтэй илтгэгч оролцсон юм. Ажигласан сонгуулийн сурталчилгааны арга хэмжээнд оролцогчид, үзэгчдийн дунджаар 56 хувь нь эмэгтэйчүүд байлаа.

<sup>61</sup> Гадаадын иргэд, олон улсын байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, харьяалалгүй хүн, насанд хүрээгүй хүн, татварын өртэй хуулийн этгээд, үйлдвэрчний эвлэл, шашны байгууллага болон байгуулагдаад нэг жил болоогүй хуулийн этгээд.

<sup>62</sup> ҮАГ нийслэл хот болон аймаг бүрд салбар нэгжтэй. [2020 оны АИХЭГ, Венецийн Комиссын Улс төрийн намын эрх зүйн зохицуулалтын хамтарсан удирдамжийн](#) 276-р догол мөрд, “Хяналтыг бодитой хэрэгжүүлэхийн тулд төв болон орон нутгийн түвшинд хяналт тавих ёстой” хэмээн зөвлөсөн.

<sup>63</sup> [Бодлогод Залуусын Хяналт](#) ТББ нь кампанит ажлын санхүүжилтэд үнэлгээ хийсэн цор ганц ИНБ юм.

<sup>64</sup> [2020 оны АИХЭГ, Венецийн Комиссын Улс төрийн намын эрх зүйн зохицуулалтын хамтарсан удирдамжийн](#) 278-р догол мөрд, “Нам болон нэр дэвшигчдийн ирүүлсэн санхүүгийн тайланд хяналт, шалгалт хийх, нягтлан бодох бүртгэлд хяналт тавих эрхийг хяналтын байгууллагад олгох ёстой” гэж зөвлөснийг үзнэ үү.

Хуульд цахим сурталчилгааны зардал нь сонгуулийн сурталчилгааны нийт зардлын 15 хувиас ихгүй байхаар хязгаарласан боловч, ҮАГ нийгмийн сүлжээний зарцуулалтад мониторинг хийдэггүй. Сонгуулийн албан ёсны сурталчилгааны үеэр Ард Түмний Ялалт гэх МАН-ыг дэмжсэн хөндлөнгийн хуудас, МАН-ын нэр дэвшигч, Соёлын сайд Чинбатын Номингийн хуудас, мөн МАН-ын нэр дэвшигч Энхбаярын Батшугарын хуудас Фейсбүүкт хамгийн их төлбөртэй сурталчилгаа явуулсан байна.<sup>65</sup> Улс төрийн намууд ҮАГ-т хүргүүлсэн сонгуулийн зардлын урьдчилсан тайланд дурдсанаас үзвэл нийгмийн сүлжээнд МАН, улмаар ХҮН нам, Үндэсний эвсэл хамгийн их мөнгө зарцуулжээ.<sup>66</sup>

*Үндэсний Аудитын газар хуулиар олгогдсон эрхээ бүрэн хэрэгжүүлж, орон нутагт буй салбар нэгжээрээ дамжуулан мэдээлэл цуглуулж, сонгуулийн кампанит ажлын санхүүжилт, зарцуулалтад үр дүнтэй мониторинг хийх ёстой.*

АИХЭГ-аас өмнө нь гаргаж байсан зөвлөмжийн дагуу 2020 оноос хойш УИХ-ын сонгуульд оролцогчид сонгуулийн зардлын болон хандивын тайлангаа санал авах өдрөөс 3 өдрийн өмнө ҮАГ-т хүргүүлж, ҮАГ түүнийг нь нийтэлдэг болсон.<sup>67</sup> ҮАГ 6 дугаар сарын 26-ны өдөр мажоритар өрсөлдөөнд нэр дэвшиж буй 969 нэр дэвшигчийн, үүнд бие даан нэр дэвшиж буй 42 нэр дэвшигч, 2 эвсэл, 19 намын нэр дэвшигчдийн явцын тайланг нийтэлжээ. Гэсэн хэдий ч, улс төрийн 5 нам тайлангаа хүргүүлээгүй тул мэдээлэл нь байхгүй байв.<sup>68</sup> Мөн, 113 нэр дэвшигч огт тайлан хүргүүлээгүй, 50 нэр дэвшигч орлогын, эсвэл зарлагын ганц тайлан илгээсэн, нийт 163 нэр дэвшигчийн тайланд зөрчил илэрсэн байна. Бодлогод Залуусын Хяналт ТББ нэр дэвшигчдийн зардлын тайланд орлого, зарлага нь нийлэхгүй тохиолдлууд байгаа тухай мэдээлэв. Улс төрийн нам, эвсэл сонгуулийн өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойг 30 хоногт багтаан эцсийн тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан хүргүүлэх үүрэг хүлээдэг. ҮАГ нь зөрчил гарсан тохиолдолд хариуцлага тооцох эрх хэмжээгүй ба харин холбогдох эрх бүхий байгууллагууд руу мэдээлэл шилжүүлнэ.<sup>69</sup> Ерөнхийдөө, АИХЭГ-аас өмнө нь зөвлөмжүүд гаргаж байсан ч, сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн орчинд хяналт тавих үр дүнтэй механизм анхааруулах арга хэмжээ авах зохицуулалт хангалтгүй байна.<sup>70</sup>

*Ил тод байдлыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэхийн тулд кампанит ажлын санхүүжилтийн эрх зүйн орчныг чангатгаж, санхүүжилттэй холбоотой зөрчилд тохирохуйц хариуцлага тооцох цогц механизмыг бий болгож, хэрэгжүүлэх ёстой.*

<sup>65</sup> [Мета Сурталчилгааны сангаас](#) авсан мэдээллээр, 6-р сарын 10-27-ны хооронд Ард түмний ялалт хуудас 49,026 евро; Чинбатын Номин 46,841 евро; МАН-ын нэр дэвшигч Энхбаярын Батшугар 35,750 евро; МАН 35,347 евро тус тус зарцуулжээ. ХҮН намын албан ёсны хуудас 27,260 евро; АН 19,794 евро; Үндэсний эвсэл 4,257 евро тус тус зарцуулсан байна.

<sup>66</sup> ҮАГ-аас өөрсдийн цахим хуудсанд нийтэлсэн [явцын тайланд](#) МАН 122,669 евро; ХҮН нам 62,810 евро; Үндэсний эвсэл 49,869 евро; Иргэний Зориг Ногоон нам 4,347 евро; АН 450 евро тус тус нийгмийн сүлжээнд зарцуулсан бол Шинэ Нэгдсэн Эвсэл нийгмийн сүлжээнд нэг ч төгрөг зарцуулаагүй тухай дурджээ.

<sup>67</sup> ҮАГ-аас тайланг яаралтай нийтлэх талаар ч, нийтлэх эцсийн хугацааг ч хуульд тодорхой тусгаагүй.

<sup>68</sup> Эдгээр намууд нь Монголын Либерал Ардчилсан нам, Эх орон нам, Бүгд Найрамдах нам, Монголын Социал Демократ нам, Эх орончдын нэгдсэн нам зэрэг болно. Ард түмний олонхын засаглал нам намынхаа биш, нэр дэвшигчдийнхээ тайланг илгээжээ.

<sup>69</sup> Хандив өгөхийг зөвшөөрсөн хүн хандив өгсөн эсэхийг Татварын улсын байцаагч; тайлантай холбоотой асуудлаар Сангийн яам; нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудлаар Төв банк.

<sup>70</sup> [2020 оны АИХЭГ, Венецийн Комиссын Улс төрийн намын эрх зүйн зохицуулалтын хамтарсан удирдамжийн](#) 272-р догол мөрд “Холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн нь тогтоогдсон улс төрийн намуудад шийтгэл ногдуулах ёстой бөгөөд энэ нь дахин гаргуулахгүй байх шинж чанартай байна. Түүнчлэн, шийтгэл ь хэрэгжүүлэх боломжтой байхаас гадна ямар ч үед бодитой, үр дүнтэй, тухайн зөрчилтэй дүйцэхүйц байх ёстой” гэжээ.



## ХІ. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

### А. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ОРЧИН

Монгол Улс 400 гаруй хэвлэл мэдээллийн хэрэгсэл бүхий олон ургалч хэвлэл мэдээллийн орчинтой. Интернэтийн өргөн хэрэглээ нь нийгмийн сүлжээний үүргийг өндөрсгөж, телевизээс гадна мэдээллийн үндсэн эх сурвалж болжээ. АИХЭГ-ын САХ-ны олон тооны ярилцагчид хэвлэлийн эрх чөлөө дордож буйг, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн эдийн засгийн тогтвортой байдал сул буйгаас мэргэжлийн түвшинд, ёс зүйн стандартыг баримталж ажиллах аргагүй болж, улмаар олон нийтийн итгэл суларч буйг онцолсон юм.<sup>71</sup> Хувийн хэвшлийн хэвлэл мэдээллийн дийлэнх нь хязгаарлагдмал зар, сурталчилгааны зах зээлд өрсөлдөж буй нь тэднийг эзэмшигчдээсээ хараат байлгадаг. Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз (МҮОНРТ) нь телевизийн 5 суваг, 3 радиотой бөгөөд урьд нь мэдээллийн цор ганц эх сурвалж байсан тул олон нийтэд харьцангуй нэр хүндтэй.<sup>72</sup> Төсөв нь улсын төсвөөс хамааралтай буюу жил бүр засгийн газар, УИХ дахь олонх шийдэж, баталдаг нь олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх зүйн, болон санхүүгийн бие даасан байдалд хамаарах олон улсын үүрэг амлалттай зөрчилддөг.<sup>73</sup>

АИХЭГ-ын САХ-ны хэд хэдэн ярилцагчийн хэлснээр маш олон хэвлэл мэдээллийн хэрэгсэл улс төрийн хамаарал бүхий, эзэмшигчид нь хэвлэл мэдээллийг үндсэн бизнес гэж үздэггүй, харин хэвлэл мэдээллийг эдийн засгийн ашиг сонирхлоо хамгаалахад улс төрийн хөшүүрэг болгон ашигладаг байна. Түүнчлэн, редакцын таатай контентод төлбөр төлөх гэх мэт гэрээнд суурилсан тогтолцоо сэтгүүлчдийн дунд өргөн ашиглагддаг гэж үздэг.

### В. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Үндсэн хуульд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулж, бусад хууль тогтоомжоор хэвлэл мэдээллийн орчныг дэлгэрэнгүй зохицуулдаг. 2017 онд гүтгэлгийг гэмт хэргээс хассан. Гэсэн хэдий ч сонгуулийн хууль тогтоомжид худал мэдээлэл тараасан тохиолдолд хариуцлага хүлээлгэх заалт хэвээр үлдэж, 2020 онд Эрүүгийн хуульд дахин оруулжээ.<sup>74</sup> Гүтгэлэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь олон улсын жишигт нийцэхгүй байна.<sup>75</sup>

Сонгуулийн үеэр АИХЭГ-ын САХ-ны ярилцагчдын мэдээлснээр төрийн байгууллага, өндөр тушаалын улс төрчид, төрийн албан хаагчдын гаргасан гомдолд үндэслэн багадаа 7 сэтгүүлч

<sup>71</sup> Хил Хязгааргүй Сэтгүүлчдээс гаргадаг [2024 оны Хэвлэлийн Эрх чөлөөний индексээр](#) 180 орноос 109-р байранд орсон нь 21 байраар ухарсан үзүүлэлт юм.

<sup>72</sup> Олон нийтийн радио телевизийн редакцын хараат бус байдал нь Олон нийтийн радио телевизийн тухай хуулиар зохицуулагддаг. Үндэсний зөвлөл нь 6 жилийн хугацаанд ажиллах 15 гишүүнээс бүрдэх бөгөөд 7 гишүүнийг УИХ, 4 гишүүнийг Ерөнхийлөгч, 4 гишүүнийг Засгийн газар нэр дэвшүүлнэ.

<sup>73</sup> 1996 оны [ИБУТЭОУЦ](#)-д 2011 оны [34-р ерөнхий санал зөвлөмжийн](#) 16-р догол мөрд “Улс орнууд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн бие даасан байдал, редакцын эрх чөлөөг баталгаажуулж, тогтвортой санхүүжилтээр хангах ёстой гэснийг үзнэ үү.

<sup>74</sup> Эрүүгийн хуулийн 13.14-р зүйлд “Хүний нэр төр, алдар хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд туст ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ” гэж заажээ. Эрүүгийн хуулийн 14.8-р зүйлд сонгуулийн үеэр худал мэдээлэл тараасан тохиолдолд хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Мөн, УИХСтХ-ийн 35.3-т нэр дэвшигчийн талаар худал мэдээлэл нийтлэх, нэр төр, алдар хүндийг нь гутаан доромжлохыг хоригложээ.

<sup>75</sup> [ИБУТЭОУЦ](#)-д 2011 оны [34-р ерөнхий санал зөвлөмжийн](#) 47-р догол мөрд “Улс орнууд гүтгэлгийг гэмт хэрэг гэж үзэхгүй байх талаар бодолцох ёстой бөгөөд эрүүгийн хуулийг зөвхөн хамгийн ноцтой тохиолдолд л хэрэглэгдэх боловч хорих ял нь хэзээ ч хамгийн оновчтой шийтгэл байдаггүй” гэжээ.

шалгагдаж байв.<sup>76</sup> Эрх зүйн орчин, хуулийн хэрэгжилт эрэн сурвалжлах сэтгүүл зүйг боомилсноос, сэтгүүл зүй өөрийгөө цензурдэхэд хүргэж, ерөнхийдөө улс төр, нийгмийн шүүмжлэлт хэлэлцүүлэг өрнүүлэхэд сөрөг нөлөө үзүүлж байна.

*Хуурамч мэдээлэл тараах, ялангуяа сонгуулийг илт чиглэсэн худал мэдээлэл түгээхтэй холбоотой эрүүгийн хуулийн заалтуудыг хүчингүй болгох ёстой. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зүй бусаар хязгаарлаж болзошгүй тул гүтгэлэгт оноосон тохиромжгүй хуулийн хариуцлагыг өөрчлөх шаардлагатай.*

УИХСтХ, ХХЗХ-ны журмууд өргөн мэдээллийн хэрэгсэл болон интернэтээр сонгуулийн сурталчилгааг хэрхэн явуулах талаар дэлгэрэнгүй зохицуулсан байна. Төлбөртэй улс төрийн контентуудыг зөвхөн хувийн хэвшлийн өргөн нэвтрүүлгийн сувгуудаар өдөрт 60 минутаас ихгүй хугацаанд дамжуулахыг зөвшөөрдөг.<sup>77</sup> Харамсалтай нь хуульд, мэдээ сурвалжилгад хязгаарлалт тавьж, нэг өрсөлдөгчийн талаар дамжуулах мэдээллийн цагийг 5 минутаар хязгаарлажээ. МҮОНРТ эфирийн цагийг өрсөлдөгчдөд тэнцүү хуваарилах үүрэгтэй бөгөөд мэтгэлцээнд зориулсан эфирийн цагаас гадна өрсөлдөгч бүрд кампанит ажлын үеэр 15 минут олгов.

Сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхэлсэн 6 дугаар сарын 10-ны өдрөөс хойш аль аль өрсөлдөөнд нэр дэвшигчдийг оролцуулсан нийт 55 мэтгэлцээн зохион байгуулагджээ. ХХЗХ-ны баталсан хуваарийн дагуу өдрийн гурван удаагийн мэтгэлцээнийг МҮОНРТ телевиз, болон радиогоор зэрэг дамжуулав. Ерөнхийдөө, МҮОНРТ нэр дэвшигчдэд эфирийн цаг үнэгүй олгох үүргээ биелүүлсэн. Гэсэн хэдий ч, мэтгэлцээний дийлэнх нь оргил бус цагаар дамжуулагдсан тулд сонгогчдод мэдээлэл олгоход үр нөлөөтэй байсан эсэх нь эргэлзээтэй.<sup>78</sup> МҮОНРТ-ийн мэтгэлцээнд нийт 304 хүн оролцсоны 24 хувь нь эмэгтэйчүүд байв.

*Өрсөлдөгч нарын талаарх мэдээ, сурвалжилгын дамжуулах дээд хязгаарыг үгүй болгож хуульд өөрчлөлт оруулж болно. Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн сувгаар кампанит ажлын хөтөлбөр нь сонгогчдод олон талт, шинэлэг хэлбэрээр тэгш хүртээмжтэй хүрэхийн зэрэгцээ тэдэнд мэдээлэл хүргэхийг зорих ёстой.*

СЕХ-г оролцуулаад олон байгууллага өргөн нэвтрүүлгийн сувгууд, цахим орчинд хяналт тавих хэдий ч ХХЗХ, Шударга өрсөлдөөн, Хэрэглэгчийн төлөөг газар (ШӨХТГ) газар голлох үүрэгтэй оролцдог.<sup>79</sup> Хуулиар ХХЗХ-нд цахим болон цахим бус хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаа түдгэлзүүлэх хүртэл өргөн эрх мэдэл олгожээ. Гэсэн хэдий ч, ХХЗХ ерөнхийдөө зөвлөх байдлаар ажиллахыг зорьж буй талаар АИХЭГ-ын САХ-нд мэдээлсэн юм. Сонгуулийн сурталчилгааны үеэр ХХЗХ 27 өргөн нэвтрүүлгийн станцад (21 телевиз, 6 радио) анхааруулга

<sup>76</sup> 2023 оны 12 дугаар сард хамгийн алдартай цахим мэдээллийн сайтуудын нэг [zarig.mn](http://zarig.mn) ерөнхий редактор худал мэдээлэл түгээсэн, хэрэгт буруутгагдан саатуулагдаж, 2024 оны 2 дугаар сард суллагдаж гэрийн хорионд оржээ. Түүнийг 2024 оны 7 дугаар сарын 19-ны өдөр худал мэдээлэл тараасан, татвараас зайлсхийсэн, мөнгө угаасан, хувийн нууцыг задруулсан, төрийн нууцыг хууль бусаар олж авсан хэрэгт буруутгаж 4 жил 9 сарын хорих ялаар шийтгэжээ.

<sup>77</sup> 83 телевизийн суваг, 42 радио станц нийт 125 өргөн нэвтрүүлгийн сувгууд мөн 245 цахим мэдээллийн хэрэгсэл улс төрийн сурталчилгаа явуулахаар СЕХ-нд бүртгүүлжээ.

<sup>78</sup> Өдөрт 10:00, 14:00, 17:50 цагуудад 3 удаагийн мэтгэлцээний дамжуулагдсан. Мэтгэлцээн бүрд 5 хүртэлх тооны зочид орох бөгөөд 6-р сарын 8-ны өдөр МҮОНРТ-ийн зохион байгуулсан сугалааны дагуу ярилцах 2 сэдвийг урьдчилан тодорхойлсон 102 сэдвээс сугалж тодруулсан. 6-р сарын 26-ны өдөр буюу сүүлийн өдрийн мэтгэлцээн (6-7 оролцогчтой 5 удаагийн мэтгэлцээн) 16 цагт эхэлж 4 цаг үргэлжлэв. Хувийн хэвшлийн Тэнгэр ТВ өдөр бүр төлбөрт мэтгэлцээний хөтөлбөрүүдийг оргил цагаар (оройн 21 цагаас) дамжуулж байсан нь үзэгчдийн анхаарлыг татаж байв. ХХЗХ-ны мэдээллээр нийт 85 мэтгэлцээн зохион байгуулагджээ.

<sup>79</sup> ХХЗХ өргөн нэвтрүүлгийн сувгууд төлбөрт сурталчилгааны цагийг дагаж буй эсэхэд, мөн, цахим контентод худал мэдээлэл тарааж буй эсэхэд мониторинг хийжээ. ШӨХТГ хөндлөнгийн гүйцэтгэгчээр дамжуулан мэдээний цагийн дээд хязгаар журамд нийцэж буй эсэхэд хяналт тавьсан ч агуулгыг нь үнэлээгүй юм.

хүргүүлсэн боловч тэд сонгуулийн өмнө ч, дараа нь ямар нэгэн арга хэмжээ аваагүй байна.<sup>80</sup> ШӨХТГ хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сонгуулийн сурталчилгаатай холбоотой гомдлын талаар албан ёсны мэдээлэл өгөөгүй. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой гомдлуудыг хүлээн авах нэгдсэн суваг байсангүй нь харамсалтай. Энэ төрлийн гомдлыг ХХЗХ, ШӨХТГ, СЕХ болон анхан шатны шүүх, цагдаагийн байгууллагад гаргаж болох талаар АИХЭГ-ын САХ-нд мэдэгдсэн юм. Гомдол хүлээн авах, шийдвэрлэхтэй холбоотой чиг үүрэг давхацсан төдийгүй зааг ялгааг нарийн тодорхойлоогүй нь хуулийн хамгаалалтыг үр дүнтэй, цаг тухайд нь авах боломжийг бууруулж байна.

*Алагчлалгүй байх хуулийн шаардлагыг үр дүнтэй, цаг тухай нь хэрэгжүүлэхийн тулд ил тод арга зүй, хангалттай нөөц бүхий бие даасан этгээдэд хэвлэл мэдээллийн орчныг хянах, хэвлэл мэдээлэлтэй холбоотой гомдол шийдвэрлэх, зохицуулах үүргийг хариуцуулах талаар бодож үзэх хэрэгтэй.*

### **С. СОНГУУЛИЙН КАМПАНИТ АЖЛЫГ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛЭЭР ДАМЖУУЛСАН БАЙДАЛ** **ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ ҮЗЭХ**

АИХЭГ-ын САХ 6 дугаар сарын 1-ний өдрөөс гол хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд медиа мониторинг хийж эхэлсэн.<sup>81</sup> Сонгуулийн кампанит ажил албан ёсоор эхлэхээс өмнө, голлох өргөн нэвтрүүлгийн сувгууд эрх баригчдын талаарх мэдээллийг эерэг, эсвэл төвийг сахисан өнгө аястайгаар өргөн хүрээнд дамжуулсан. Харин сурталчилгааны үеэр мониторинг хийсэн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд МАН, АН зэрэг гол улс төрийн хүчний талаар илүү дамжуулж байлаа.

АИХЭГ-ын САХ-ны хийсэн медиа мониторингийн үр дүнд мэдээний хөтөлбөрт улс төрийн намууд бэлтгэн нийлүүлсэн сурвалжилга, төлбөртэй улс төрийн сурталчилгаа гэх тэмдэгтэй мэдээнүүд цацаж байсан тул хараат бус редакцын бодлого хомс буй нь харагдсан. Мэдээний хөтөлбөр, эрэн сурвалжилсан, задлан шинжилсэн хөтөлбөрүүд хомс буй нь сонгогчид мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргах чадварт сөрөг нөлөөлж байна. МҮОНРТ албан ёсны сонгуулийн кампанит ажлын үеэр МАН-ыг илэрхий дамжуулж байлаа. МҮОНРТ мэдээ, сурвалжилгын цагийн 37 хувийг МАН-д зарцуулсан нь эерэг, эсвэл төвийг сахисан өнгө аястай байв.

*Улс төрийн аль нэг хүчинд илүү үйлчлэхээс сэргийлж, алагчлаагүй, олон талт редакцын бодлогыг баримталж, үнэн зөв мэдээлэх зорилгоор олон нийтийн өргөн нэвтрүүлгийн сувгийн бие даасан байдлыг хүчирхэгжүүлэх тал дээр анхаарах шаардлагатай.*

Мониторинг хийсэн бусад сувгуудад ч ойролцоо дүр зураг ажиглагдсан. Хамгийн илэрхий нь, ерөнхийлөгч асан Намбарын Энхбаярын эзэмшдэг ТВ9 телевиз мэдээний цагийн 68 хувийг, Соёлын сайд Номингийн хувь эзэмшдэг Монгол телевиз 50 хувийг МАН-д тус тус зарцуулсан бөгөөд үлэмж хувь нь эерэг өнгө аястай байлаа. NTV телевиз эрх баригч МАН-ыг шүүмжилсэн бол, Ийгл телевиз гол өрсөлдөгчдийн талаар тэнцвэрт мэдээллийг дамжуулсан.

Мониторингд хамрагдсан цахим мэдээллийн хэрэгслүүдийн дийлэнх нь улс төр, сонгуультай холбоотой мэдээллийн үлэмж хэсгийг МАН-д зарцуулсан нь 23-42 хувийн хооронд хэлбэлзсэн бөгөөд эрх баригч намыг эерэг буюу төвийг сахисан байдлаар мэдээлэв. Нөгөө талаар, *itoim.mn* МАН-ын талаар шүүмжлэлтэй хандаж, мэдээллийнхээ ихэнхийг АН-д (39 хувь) зарцуулсан

<sup>80</sup> 2024 оны 7 дугаар сарын 7-ны өдөр нийтэлсэн [ХХЗХ-ны сонгуулийн сурталчилгааны хяналтын нэгдсэн тайлан](#) үзнэ үү.

<sup>81</sup> Үүнд, МҮОНРТ, (радио, ТВ аль аль нь) хувийн хэвшлийн Ийгл ТВ, Монгол ТВ, NTV, TV9, MN25 телевиз болон цахим мэдээний [eguug.mn](#), [gogo.mn](#), [ikon.mn](#), [itoim.mn](#), [news.mn](#), [zarig.mn](#) зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг хамруулав. Мониторингийн хүрээнд тоон болон чанарын арга зүй ашиглан оргил цагийн ТВ-ийн мэдээллийн хөтөлбөрүүд, улс төрийн болон сонгуулийн холбогдолтой контентуудад төвлөрч өрсөлдөгчдийн болон улс төрийн этгээдүүдийн хэвлэл мэдээлэлд эзлэх цаг, хэмжээг үнэлэхийг зорьсон.



байна. Бусад цахим мэдээллийн хэрэгслүүдийн мэдээнд АН-ын 12-33 хувийг эзэлсэн бөгөөд төвийг сахисан өнгө аястай байлаа.

Олон нийтийн, болон улс төрийн амьдралд эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй байдал хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ч мөн адил тусгагдсан байна.<sup>82</sup> Мониторинг хийсэн телевизийн сувгуудад эмэгтэй нэр дэвшигчид 9-35 хувийг эзэлсэн бол, цахим мэдээллийн хэрэгсэлд улс төр, сонгуультай холбоотой мэдээллийн 9-19 хувь байсан юм.

## ХИИ. СОНГУУЛЬ АЖИГЛАЛТ

Хуульд иргэд, сонгуульд өрсөлдөгч нарын хууль ёсны төлөөлөл болон олон улсын байгууллагаас сонгууль ажиглах боломжоор хангажээ. Хуульд нэг байгууллагаас, нэг санал авах байранд хоёроос илүүгүй ажиглагч байхаар хязгаарлаж, төрийн албан хаагч сонгууль ажиглахыг хориглосон. Улс төрийн нам, эвслүүд мөн ажиглагчдаа санал авах байранд томилох боломжтой.

Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээ хэсэг бүлэг ИНБ-ыг чиглүүлж сонгогчийн бүртгэл, нийгмийн сүлжээнд болон бусад хэрэгслээр явж буй сонгуулийн сурталчилгаа, сонгуулийн санхүүжилт болон сонгуульд технологи ашиглах зэрэг асуудлаар ажиглалт хийсэн.<sup>83</sup> СЕХ-ноос нийт олон улсын 259 ажиглагчдад итгэмжлэл олгосон ба, иргэний нийгмийн 300 гаруй ажиглагчид, улс төрийн намын ойролцоогоор 29,000 ажиглагчид СХХ-нд ажиглагчаар бүртгэгдсэн талаар мэдээлсэн юм.<sup>84</sup>

Сонгууль ажиглах иргэний бүртгэлийг хөнгөвчлөхийн тулд СЕХ тэднийг ажиглах хэсгийн хороогоо тодорхойлж, цахим платформд бүртгэлээ хийхийг шаарддаг. Гэсэн хэдий ч, сонгуулийн хэсгийн хорооны ажилчид иргэний ажиглагчдаас нэмэлт бичиг баримт асуусан нь шаардлагагүй алхам бөгөөд үйл явцыг төвөгтэй болгож байсан юм.

*Иргэний ажиглагчдын бүлгүүд саадгүй нэвтрэх, зохион байгуулалтын хүндрэлийг багасгахын тулд сонгууль эрхэлсэн байгууллагууд ажиглагчид санал авах байр бүрээр бүртгүүлэх шаардлагыг цуцлах талаар бодож үзэх хэрэгтэй.*

## ХИИ. СОНГУУЛИЙН МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

Гомдлын төрлөөс хамааран шүүх байгууллага, сонгууль эхэлсэн байгууллагууд сонгуулийн маргааныг шийдвэрлэнэ. Доод шатны сонгуулийн хорооны шийдвэртэй холбоотой гомдлыг дээд шатны сонгуулийн хороонд хандаж гаргадаг. СЕХ-ны шийдвэрт холбогдох маргааныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, Улсын Дээд Шүүх хяналтын журмаар хянан шийдвэрлэнэ. Санал хураалтын дүнтэй холбоотой СЕХ-ны шийдвэртэй холбоотой гомдлыг дурын иргэн Үндсэн Хуулийн Цэцэд гаргах боломжтой. Сонгуультай холбоотой зөрчил, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг цагдаагийн байгууллага шалгаж, дүүргийн

<sup>82</sup> [2022 онд АИХЭГ, Венецийн Комиссоос хамтран гаргасан Улс төрийн намын тухай хуулийн төсөлд өгөх саналын](#) 99-р догол мөрд, эмэгтэй нэр дэвшигчдэд зарцуулах мэдээ, сурвалжилгын доод хязгаарыг тавих талаар зөвлөсөн.

<sup>83</sup> Сүлжээ нь Сонгогчдын боловсрол төв, МИДАС, Баримт шалгах төв, Бодлогод залуусын хяналт, Глоб Интернэшнл төвөөс бүрдэх бөгөөд Нээлттэй Нийгэм Форумтай хамтран зохион байгуулдаг. Сүлжээ нь сонгуулийн өдөр нийслэлд 280 ажиглагчийг 140 санал авах байранд, 12 аймагт 25 ажиглагч илгээн сонгууль ажигласан.

<sup>84</sup> СЕХ нь 21 байгууллагаас томилсон 40 улсын 259 олон улсын ажиглагчдад итгэмжлэл олгосон. Мөн СЕХ Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг гадаадын байгууллага болон дипломат төлөөлөгчийн газруудад урилга илгээж 68 олон улсын ажиглагчдад нэмж итгэмжлэл олгосон.

шүүх шийдвэрлэнэ. АИХЭГ-ын САХ-той уулзаж ярилцсан хүмүүсийн зарим нь шүүхийн хараат бус байдалд олон нийт итгэл алдарч буй тухай цохон тэмдэглэсэн.<sup>85</sup>

Шүүхэд сонгуультай холбоотой хэрэг маргааныг шуурхай шийдвэрлэх журам айхгүй. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар шүүх маргааныг 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх бөгөөд энэ хугацааг нэг удаа 10 хүртэл хоногоор сунгаж болно. Улсын Дээд Шүүхэд давж заалдсан гомдлыг 21 хоногийн хугацаанд хянан шийдвэрлэдэг. Мөн УИХСтХ-д сонгуулийн гомдол маргааныг сонгуулийн жилд багтаан шийдвэрлэнэ гэж заасан нь бусад хуулийн зүйл заалттай зөрчилддөг. АИХЭГ-аас өмнө нь зөвлөмж гаргаж байсан төдийгүй, бодит байдалд шүүх сонгуультай холбоотой маргааныг цөөн хоногийн дотор шийдвэрлэхийг эрмэлзэн ажилладаг ч, сонгуулийн маргаан шийдвэрлэх хугацаа нь сонгуулийн цаг хугацааны хуваарьтай уялдахгүй хэвээр байна.<sup>86</sup> Үр дүнд нь, хэрэг хянан шийдвэрлэх цаг хугацаа нь оновчтой биш, зөрчигдсөн эрхийг сэргээхэд хүндрэлтэй байна.

Сонгуулийн жил эхэлснээс хойш 7 дугаар сарын 23-ны өдрийг хүртэлх хугацаанд сонгуультай холбоотой нийт 786 гомдол, мэдээлэл цагдаагийн байгууллагад ирснээс зөрчлийн шинжтэй 789, гэмт хэргийн шинжтэй 474 гомдол мэдээлэл бүртгэгдсэн байна. Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн дийлэнхийг нь хэрэгсэхгүй болгож, 8 хувийг нь (32 хэрэг) бусад байгууллагад шилжүүлж, 5 хувийг нь (19 хэрэг) дахин нээж, мөрдөн шалгаж байна. Цагдаагийн Ерөнхий Газрын мэдээлснээр, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 56 хувь нь сонгуулийн үеэр худал мэдээлэл түгээсэн, 27 хувь нь санал худалдаж авахыг завдсан гэх гомдлууд эзэлж байна. Харин захиргааны шинжтэй гомдол мэдээллийн дийлэнхийг хуульд зөвшөөрөгдөөгүй аргаар сурталчилгаа хийсэн, сонгуулийн материал устгаж, сүйтгэсэн гэх гомдол эзэлж байв.

Сонгуулийн өмнөх хугацаанд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд нам, нэр дэвшигчийн бүртгэлтэй холбоотой нийт 15 нэхэмжлэх ирсэн. Үүнээс 5 нэхэмжлэлийг шүүх хүлээн авахаас татгалзжээ. Шүүхээр шийдвэрлүүлсэн 10 маргааны тавынх нь нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, СЕХ-ны шийдвэрийг хүчингүй болгож, нэр дэвших боломжоор нь хангасан байна. Дээрх шийдвэрүүдийн 4 нь сонгуулийн сурталчилгаа эхэлснээс хойш гарсан бөгөөд хамгийн сүүлийн шийдвэр 6 дугаар сарын 16-нд гарчээ. Эдгээр 15 маргааны нэг нь ч Улсын Дээд Шүүхэд давж заалдаагүй юм.

*Хуулиар эрхээ сэргээлгэх ажлыг үр дүнтэй, цаг тухайд нь хэрэгжүүлэхийн тулд сонгуулийн маргааныг шийдвэрлэхдээ сонгуулийн хуваарьт уялдуулан үндэслэлтэй тогтоох талаар хуульд өөрчлөлт оруулах ёстой.*

Сонгуулийн дүнг зарласны дараа СЕХ-нд 20 гаруй гомдол, хүсэлт ирсний дийлэнх нь суудал хуваарилах босгыг эсэргүүцсэн бөгөөд аль хэдийнээ олон нийтэд ил болсон мэдээллийг СЕХ-ноос шаардсан хүсэлтүүд байв. 7 дугаар сарын 2-ны өдөр Үнэн ба Зөв нам УИХСтХ-д улс төрийн нам, эвсэлд суудал хуваарилахад босго шаардаж буй нь Үндсэн хууль зөрчиж буй талаар Үндсэн Хуулийн Цэцэд гомдол гаргав. Мөн, тэд СЕХ улс төрийн намд суудал хуваарилахдаа авсан хувиас үл хамааран авсан суудалд нь үндэслэх ёстой гэсэн юм. Сонгуулийн дараа 7 дугаар сарын

<sup>85</sup> 2023 оны Шүүгч, хуульчдын хараат бус байдлын асуудал хариуцсан [Тусгай илтгэгчийн урьдчилсан ажиглалтуудад](#) шүүх эрх мэдэлд итгэх итгэл байхгүй байгаа талаар болон шүүгчдийг гутаан доромжлох зорилгоор нийгмийн сүлжээг ашиглах асуудлуудыг хөндсөн байна. Зарим тохиолдолд төрийн албан тушаалтнууд хүртэл үүнд оролцдог. Авлигын эсрэг хараат бус байгууллагаас 2022 онд гаргасан [Хууль сахиулах байгууллагуудын авлигын талаарх тайланд](#) шүүх болон прокурорын газруудыг авлигад хамгийн их автсан байгууллагуудын нэг гэж үзсэн байна.

<sup>86</sup> [Сонгуулийн асуудлаарх сайн туршлага](#) II.3.3.3 дах хэсэг болон II.3.3.3.g хэсгүүдэд эрхээ сэргээлгэх үр дүнтэй, түргэвчилсэн механизм санал болгосныг үзнэ үү.

17-ны өдөр нэхэмжлэгч, намын дарга АИХЭГ-ын САХ-нд сонгуулийн дүн эцэслэн гарах хүртэл Үндсэн Хуулийн Цэц гомдлынх нь дагуу ямар нэг үйл явц эхлүүлээгүй талаар мэдээлсэн.<sup>87</sup>

*Сонгуулийн үр дүнтэй холбоотой маргаан цаг алдалгүй шийдвэрлэгдэх ёстой. Хуулийн тодорхой байдлыг хангахын тулд Сонгуулийн Ерөнхий Хороо сонгуулийн эцсийн үр дүнг өргөн барьж, сонгогдсон гишүүд тангараг гаргахаас өмнө маргаан шийдвэрлэгдэх ёстой.*

#### **XIV. СОНГУУЛИЙН ӨДӨР**

Сонгуулийн өдөр нам гүм, эмх цэгцтэй болж өнгөрлөө. Санал авах үйл явц ерөнхийдөө журмын дагуу явагдсан боловч, зарим санал авах байранд санал тоолох төхөөрөмжийг буруу барлуулсан, хэт их ачаалал үүссэн, улмаар саналын нууцлал алдагдахад хүрсэн гэх мэт санал авах байрны зохион байгуулалттай холбоотой тохиолдлууд ажиглагдсан. СЕХ сонгуулийн ирцийн мэдээллийг өдрийн туршид үзүүлж, санал өгөх хугацаа дуусмагц сонгуулийн үр дүнг дамжуулж эхэлсэн нь тод байдлыг хангахад чухал хувь нэмэр юм. Сонгуулийн ирц 69,3 хувь байсан талаар мэдээлсэн. Албан ёсны санал тооллого автоматаар явагдаж, дүнг СЕХ-ны төв сервер рүү шууд дамжуулав. Гэсэн хэдий ч сонгуультай холбоотой дүрэм, журмын хэрэгжилт нь сонгуулийн хэсгийн хорооны түвшинд санал хураалт хаагдах, гар тооллого хийх үед хангалтгүй байсан ба зарим тохиолдлуудад сонгуулийн өдөртөө багтааж тоолж дуусгаагүй байна.

Санал авах үйл ажиллагааны эхлэлийг санал авах 75 байранд, санал өгөх үйл ажиллагааг улс даяар санал авах 650 байранд ажиглалаа. Санал тоолох үйл явцыг санал авах 64 байранд ажигласан ба АИХЭГ-ын САХ-ны ажиглагчид СЕХ-нд санал тоолох үйл явцыг ажигласан.

##### **A. НЭЭЛТ БА САНАЛ ӨГӨХ ҮЙЛ ЯВЦ**

Санал авах байрууд яг цагтаа, зарим тохиолдолд үл ялиг хоцорч нээгдсэн. Сонгуулийн нээлтийн үйл ажиллагааг санал авах 75 байранд ажигласнаас 69-т нь эерэг үнэлгээ өгсөн ба дүрэм, журмууд чанд мөрдөгдсөн байна. Саналын хайрцгийг битүүмжлэхээс өмнө хоосон болохыг сонгуулийн хэсгийн хорооны гишүүд харуулаагүй 5 тохиолдол бүртгэгджээ.

ОУСАХ-ны ажиглагчид нийт ажиглалт хийсэн санал авах байрны 98 хувьд нь санал хураалтын явцыг эергээр үнэлж, зохион байгуулалт сайтай, саадгүй явагдсан гэж дүгнэжээ. Ажиглалт хийсэн нийт санал авах байрны 14 хувьд нь сонгогч нууцаар саналаа өгөхөд танхимын зохион байгуулалт муутай, ялангуяа Улаанбаатар хотод санал авах байрны 10 хувь нь хэт ачаалал үүссэнээс, сонгогч, сонгуулийн хэсгийн хорооны гишүүд, СТТ-тэй хэт ойр байсан зэрэг зөрчил ажиглагдав.<sup>88</sup> Ажиглалтын 22 хувьд, ОУСАХ-ны ажиглагчид санал авах байрны гадаа олон тооны сонгогчид урт дараалал үүссэн талаар тэмдэглэсэн. Ажигласан санал авах байрны 7 хувьд нь СТТ-тэй холбоотой техникийн асуудал үүссэнээс бага зэрэг саатал учирч, зарим тохиолдолд СТТ-ийг солиход хүрч байлаа.

Санал авах байранд ажиллаж буй хүмүүсийн дийлэнх нь эмэгтэйчүүд эзэлж байлаа. Ажигласан санал авах байрны ажилчдын 85 хувийг, СХХ-ны дарга нарын 78 хувь нь эмэгтэйчүүд байв. Ажиглалт хийсэн санал авах байрны 99 хувьд нь улс төрийн нам, нэр дэвшигчдийн ажиглагч нар байсан нь ил тод байдлыг хангахад чухал хувь нэмэр оруулав.<sup>89</sup> Гэвч, санал авах байрны 9 хувьд

<sup>87</sup> Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 21.2-т, “Үндсэн хууль зөрчсөн тухай иргэнээс гаргасан өргөдөл, мэдээллийг хүлээн авсан гишүүн анхны шалгалтыг 14 хоногийн дотор хийж маргаан үүсгэх эсэхийг өөрийн санаачилгаар шийдвэрлэнэ” гэжээ.

<sup>88</sup> Сонгогчид саналын хуудсаа ихэвчлэн дээш нь харуулан уншуулж байсан тул саналын хайрцагт ойрхон зогсож буй хүн сонгогчийн саналаа хэрхэн өгч буй харах боломжтой байлаа.

<sup>89</sup> Ажигласнаар АН 97, МАН-96, ХҮН нам 41, Үндэсний эвсэл 30 хувьд нь ажиглагч томилсон байна.

нь ажиглагчдад санал өгөх үйл явцыг тодорхой харах харууц байсангүй. Санал авах байрны 12 хувьд нь иргэний ажиглагчид байсны дийлэнх нь хотод байсан юм. ОУСАХ-ны ажиглагчид санал авах байранд цагдаагийн албан хаагч нэлээд (36 хувь) байсныг онцлон тэмдэглэв.<sup>90</sup> Хуульд цагдаагийн албан хаагч байлцахыг хориглоогүй, тэр байтугай санал авах, санал тоолох үед сонгуулийн материалыг цагдаагийн албан хаагч хамгаалах үүргийг хуульд тодорхойлсон боловч сонгуулийн үйл явцад цагдаа хөндлөнгөөс оролцсон цөөн тохиолдолд гарсан байна.

*Цагдаагийн албан хаагч санал авах байрны дотор байхыг хязгаарлах, гагцхүү СХХ-ны ажилтны хүсэлтээр санал авах байр руу нэвтрэх зохицуулалтыг эргэцүүлж үзэх хэрэгтэй. Үгүйдээ л санал авах байранд цагдаагийн албан хаагчийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон ёс зүйн дүрэм боловсруулж, цагдаа албан үүргээ үр дүнтэйгээр, хөндлөнгийн оролцоогүйгээр гүйцэтгэх боломжийг олгох ёстой.*

Санал авах байранд ерөнхийдөө хууль, журмын дагуу ажилласан боловч ажигласан санал авах байрны 14 хувьд нь сонгогч хурууны хээгээ уншуулахад алдаа гарсан байна. Сонгууль зохион байгуулж буй төрөл бүрийн албан хаагчдын хэлснээр хурууны хээ нь насжилтаас шалтгаалж өөрчлөгддөг тул хурууны хээ таниагүй тохиолдолд гол төлөв ахмад сонгогчдод тохиолдсон бөгөөд журмын дагуу иргэний үнэмлэхээр нь баталгаажуулжээ. Санал авах байрны 6 хувьд нь гэр бүлээрээ хамтран санал өгсөн тохиолдол гарсан бөгөөд голцуу орон нутагт болсон байна. Ажиглалтын 7 хувьд нь зарим сонгогчид журмын дагуу иргэний үнэмлэх шалгуулахгүй, хурууны хээгээр сонгогчийн баталгаажуулалт хийж санал өгчээ. Санал авах байрны 18 хувьд нь тухайн хаягт бүртгэлгүй сонгогч ирснээс өөр санал авах байр руу очиж саналаа өгөх тухай зааварчилгаа аваад гарсан тохиолдлыг ОУСАХ-ны ажиглагчид тэмдэглэв.

ОУСАХ-ны ажиглагчид сонгуулийн луйвардах оролдлого, эсвэл ноцтой зөрчил ажиглаагүй. Улс төрийн намын ажиглагчид сонгогчийн баталгаажуулалтын үеэр дэлгэцэд харагдах зургийг дарж байсан тохиолдол гарсан нь сонгогчийн хувийн нууцад халдаж байж болзошгүй юм.

СЕХ харааны бэрхшээлтэй сонгогчдод зориулж санал авах байрны 93 хувьд нь брайл үсэгтэй маягт, 98 хувьд нь томруулдаг шил байрлуулах гэх мэт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог дэмжих арга хэмжээг авсан боловч санал авах байрны ердөө 40 хувь нь бие эрхтний бэрхшээлтэй сонгогчид бие даан санал өгөхөд тохиромжтой байсан юм.

## **В. САНАЛ ТООЛОХ, ДҮНГ НЭГТГЭХ**

СЕХ санал хураалтын ирцийн мэдээг олон давтамжтай танилцуулсан нь ил тод байдлыг хангахад чухал хувь нэмэр оруулсан. Ирцийн мэдээг сонгуулийн тойргоор, аймгаар, сонгогчдын нас, хүйсээр ангилан мэдээлсэн. Бүх санал авах байр цагтаа хаасан бөгөөд сонгуулийн ирц 69.3 хувь байв. Залуу сонгогчдын ирц мэдэгдэхүйц сул, тодруулбал 18-19 нас (эрэгтэй сонгогчдын 61.3, эмэгтэй сонгогчдын 63 хувь), 20-24 нас (эрэгтэй сонгогчдын 49.6, эмэгтэй сонгогчдын 43.7 хувь), 25-29 насны (эрэгтэй сонгогчдын 52.1, эмэгтэй сонгогчдын 61.5 хувь) сонгогчдын идэвх харьцангуй сул байгааг харуулж байна. Эмэгтэй сонгогчдын ирц эрэгтэй сонгогчдын ирцээс 8 хувиар өндөр байлаа.

Санал хураалт дууссаны дараа СЕХ сонгуулийн урьдчилсан дүнг сонгуулийн тойрог, өрсөлдөгч тус бүрээр дамжуулж эхэлсэн бөгөөд тус мэдээлэл нь санал авах байр тус бүрээр харуулсангүй. Сонгуулийн урьдчилсан дүнг нэгтгэх үйл явцыг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд СЕХ-ноос өргөн хүрээнд шууд дамжуулсан ч, СЕХ өөрсдийн цахим хуудсанд урьдчилсан дүнг нийтэлсэнгүй.

<sup>90</sup> 2017 онд АИХЭГ-аас гаргасан [Сонгуулийн үеэр олон нийтийн аюулгүй байдлыг хангагчдад зориулсан удирдамжийн](#) 51-р хуудсанд “Сайн туршлагаас үзэхэд сонгуулийн хэсгийн хороодод цагдаа нар байхыг ерөнхийдөө хориглодог бөгөөд гагцхүү дэг журам тогтоох, тодорхой зөрчилд хариу арга хэмжээ авахаар сонгуулийн албан хаагчийн хүсэлтээр санал авах байранд орохыг зөвлөдөг” гэжээ.

СЕХ 6 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд сонгуулийн эцсийн үр дүнг нийтлэхдээ, АИХЭГ-аас өмнө гаргаж байсан зөвлөмжүүдийг үл харгалзан сонгогчдын ирц санал авах байр тус бүрийн сонгогчдын ирц гэх мэт сонгогчдын бүртгэлтэй холбоотой мэдээлэл, нийт өгсөн болон устгасан саналын хуудас гэх мэт санал хураалттай холбоотой нэмэлт мэдээллийг нийтлээгүй гагцхүү санал өгсөн сонгогчдын хүн ам зүйн мэдээллийг нийтэлсэн юм. Сонгуулийн үр дүнг нийтлэх нь хуулиар зохицуулагдаагүй, гагцхүү СЕХ-ны өөрсдийн санаачилгаар зохицуулагддаг.

*Ил тод байдлыг хангахын тулд СЕХ сонгуулийн урьдчилсан болон эцсийн үр дүнг санал авах байраар нь задлан харуулсан мэдээллийг нэн даруй цахим хуудаснаа нийтлэх ёстой. Сонгуулийн үр дүнг бодитоор нягтлахад нийтэлсэн үр дүн нь бүртгэгдсэн сонгогчдын тоо, нэр дэвшигч тус бүрийн авсан саналын тоо, хоосон саналын хуудас, нийт хүлээн авсан болон устгасан саналын хуудасны тоо зэрэг мэдээллийг агуулах ёстой.*

## XV. СОНГУУЛИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВЦ

Сонгуулийн үр дүнд эргэлзсэн өрсөлдөгч гарсангүй, сонгуулийн дараах орчин үндсэндээ нам гүм байлаа. Гэвч, сонгуулийн урьдчилсан үр дүнг зарлахтай зэрэгцэн, АН, Үндэсний эвсэл, Иргэдийн Оролцооны Нэгдэл нам зэрэг сөрөг хүчний намын удирдлагууд мэдэгдэл хийж эрх баригч намыг сонгуультай холбоотой маш их зөрчил гаргасан гэж буруутгасан бол, МАН хариуд нь АН санал худалдаж авах болон сонгуулийн хуулийг зөрчсөн үйлдлүүд гаргасан гэжээ.<sup>91</sup>

СЕХ-ноос нийтэлсэн сонгуулийн эцсийн үр дүнд МАН 68 суудал авснаар УИХ-д олонхын байр сууриа хадгаллаа. АН 42, ХҮН нам 8, Үндэсний эвсэл, Иргэний Зориг Ногоон нам тус бүр 4 суудал авчээ. УИХ-д эмэгтэйчүүдийн төлөөлөл 76-аас 13 байсан бол шинээр сонгогдсон УИХ-д 126-аас 32 (25 хувь) болж өслөө. Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ сөрөг хүчний намуудыг засгийн газарт урьж, 7 дугаар сарын 10-ны өдөр МАН-аас 12, АН-аас 8, ХҮН намаас 2, шинэ засгийн газрын нийт 22 сайдыг томилсноос 3 нь эмэгтэй байна. Үндэсний эвсэл, Иргэний Зориг Ногоон нам УИХ-д сөрөг хүчний намууд болж үлдэв.

## XVI. ЗӨВЛӨМЖ

Тус тайлангийн хэсэг бүрд дурдсан эдгээр зөвлөмжүүд Монгол Улс цаашид сонгууль зохион байгуулахад ЕАБХАБ-ын болон бусад олон улсын өмнө хүлээсэн үүрэг амлалт, ардчилсан сонгуулийн стандартуудад бүрэн нийцүүлэхэд дэмжлэг болгох үүднээс харгалзан үзэхийг хүсэж, санал болгож байна. Эдгээр зөвлөмжийг АИХЭГ-аас өгсөн өмнөх зөвлөмжүүдтэй хамтад нь

<sup>91</sup> Сонгуулийн өдөр санал хураалт хаагдсаны дараа АН сонгуулийн сурталчилгааны үеэр сонгуулийн хууль зөрчсөн хэд хэдэн тохиолдол гарсан гэж мэдэгдэв. Үндэсний эвслийн тэргүүн эрх баригч нам хууль сахиулах байгууллагыг үнэмлэхүй хяналтдаа байлгаж, эвслийн сурталчилгааг үймүүлэх зорилгоор цагдааг ашигласан талаар мэдээлсэн бол Иргэдийн Оролцооны Нэгдэл нам сонгогчдыг сүрдүүлэх, санал худалдаж авах, төрийн албан хаагчдыг дарамтлах зэрэг хэд хэдэн зөрчил гарсан талаар мэдээлсэн. Тухайн өдөр, МАН-ын Намын байгуулалтын газрын дарга АН-аас санал худалдаж авах болон сонгуулийн хууль зөрчсөн хэд хэдэн тохиолдол гарсан талаар мэдэгдэв.

уншвал зохистой.<sup>92</sup> Эрх зүйн шинэчлэлийг хийхдээ иргэний нийгмийн болон бусад талуудыг оролцуулсан хэлэлцүүлгүүд өрнүүлж, сонгууль болохоос хангалттай хугацааны өмнө хийх хэрэгтэй. АИХЭГ нь Монгол Улсын эрх бүхий байгууллагуудыг цаашид сонгуулийн үйл явцаа сайжруулах, энэ болон өмнөх тайлангуудад тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэхэд нь туслахад бэлэн байна.

#### **А. НЭН ТЭРГҮҮНИЙ ЗӨВЛӨМЖҮҮД**

1. Эрх зүйн болон үйл ажиллагааны тодорхойгүй байдал үүсэхээс сэргийлж, хяналтын тооллого зохион байгуулахад шаардлагатай алхам бүрийг тусгасан хяналтын тооллогын тодорхой журам боловсруулах ёстой. Түүнчлэн, төхөөрөмжөөр тоолсон дүн, гар тооллогын дүн хоорондоо зөрсөн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой зохицуулалт тусгах шаардлагатай.
2. Оюуны бэрхшээлтэй гэх үндэслэлээр сонгох эрхийг хязгаарласан заалтуудыг халж, шоронд ял эдэлж буй иргэдийн сонгох эрхийг бүрмөсөн хасаж буй асуудлын олон улсын өмнө хүлээсэн үүрэгтэй нийцүүлж шинэчлэх шаардлагатай.
3. Хуульд захиргааны нөөц ашиглах, төрийн албан хаагчдад кампанит ажилтай холбоотой дарамт үзүүлэх зэргийг тодорхойлж, хориглох, мөн төрийн албан хаагчдын албан үүрэг, сурталчилгааны үйл ажиллагааг тодорхой зааж, зааглах ёстой. Эрх мэдэлтнүүд үүнтэй холбоотой аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, арилгах талаар идэвх санаачилгатай арга хэмжээ авах ёстой.
4. Ил тод байдлыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэхийн тулд кампанит ажлын санхүүжилтийн эрх зүйн орчныг чангатгаж, санхүүжилттэй холбоотой зөрчилд тохирохуйц хариуцлага тооцох цогц механизмыг бий болгож, хэрэгжүүлэх ёстой.
5. Хуурамч мэдээлэл тараах, ялангуяа сонгуулийг илт чиглэсэн худал мэдээлэл түгээхтэй холбоотой эрүүгийн хуулийн заалтуудыг хүчингүй болгох ёстой. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зүй бусаар хязгаарлаж болзошгүй тул гүтгэлэгт оноосон тохиромжгүй хуулийн хариуцлагыг өөрчлөх шаардлагатай.
6. Хуулиар эрхээ сэргээлгэх ажлыг үр дүнтэй, цаг тухайд нь хэрэгжүүлэхийн тулд сонгуулийн маргааныг шийдвэрлэхдээ сонгуулийн хуваарьт уялдуулан үндэслэлтэй тогтоох талаар хуульд өөрчлөлт оруулах ёстой.
7. Сонгуулийн үр дүнтэй холбоотой маргаан цаг алдалгүй шийдвэрлэгдэх ёстой. Хуулийн тодорхой байдлыг хангахын тулд Сонгуулийн Ерөнхий Хороо сонгуулийн эцсийн үр дүнт өргөн барьж, сонгогдсон гишүүд тангараг гаргахаас өмнө маргаан шийдвэрлэгдэх ёстой.

<sup>92</sup> [1999 оны ЕАБХАБ-ын Истанбулын Баримт бичгийн](#), 25-р догол мөрд, Төр улсууд “АИХЭГ-ын сонгуулийн үнэлгээний зөвлөмжүүдийг нэн даруй хэрэгжүүлэх” үүрэг хүлээсэн. Өмнө гаргасан зөвлөмжүүдийн хэрэгжилтийг АИХЭГ-ын САХ дараах байдлаар үнэлэв: 2016 оны УИХ-ын сонгууль ажиглалтын эцсийн тайлангийн 8, 11, 14, 17, 18, 28 дугаар зөвлөмжүүд, 2017 оны Ерөнхийлөгчийн сонгууль ажиглалтын эцсийн тайлангийн 10, 12 дугаар зөвлөмжүүд бүрэн хэрэгжсэн. 2016 оны УИХ-ын сонгууль ажиглалтын эцсийн тайлангийн 1, 9, 10, 27 дугаар зөвлөмжүүд, 2017 оны Ерөнхийлөгчийн сонгууль ажиглалтын эцсийн тайлангийн 2 дугаар зөвлөмж ерөнхийдөө хэрэгжсэн. 2016 оны УИХ-ын сонгууль ажиглалтын эцсийн тайлангийн 3, 5, 15, 26 дугаар зөвлөмжүүд, 2017 оны Ерөнхийлөгчийн сонгууль ажиглалтын эцсийн тайлангийн 3, 19, 22, 23, 27, 28 дугаар зөвлөмжүүд, 2021 оны Ерөнхийлөгчийн сонгууль ажиглалтын 1, 9, 14, 21, 24, 25, 27 дугаар зөвлөмжүүд хэсэгчлэн хэрэгжсэн. Дэлгэрэнгүйг [АИХЭГ-ын Сонгуулийн зөвлөмжийн сангаас](#) үзнэ үү.

## **В. БУСАД ЗӨВЛӨМЖҮҮД**

### **Хууль эрх зүйн, ба сонгуулийн тогтолцоо**

8. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, улс төрийн олон ургалч үзэл, бие даасан байдлыг баталгаажуулахын тулд хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулж улс төрийн намын гишүүнчлэл, намын дотоод зохион байгуулалтад тавьсан шаардлагагүй хязгаарлалтуудыг арилгах ёстой.
9. Хуулийн хохирол барагдуулах үр дүнтэй механизмыг бий болгохын тулд улс төрийн намыг бүртгэхээс татгалзсан тохиолдолд хуулийн хамгаалал хүсэх бололцоог олгох зохицуулалтыг нэмэлт, өөрчлөлтөөр тусгах эсэхийг анхаарч үзэх хэрэгтэй.
10. Өмнө нь зөвлөмж гаргаж байсанчлан, саналын тэгш байдлыг хангахад олон нийтийн хил хязгаарыг хадгалахад анхаарч, сонгуулийн тойрогт ногдох сонгогчдын дундаж тооноос гажуудаж болох дээд хязгаарыг үндэслэлтэйгээр тодорхойлж хуульчлах ёстой.

### **Сонгуулийн байгууллага**

11. Ил тод байдлыг хангах, олон нийтийн сонирхсон мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэхийг тулд бүх шатны сонгуулийн хороод нээлттэй хуралдаан хийх, хурлын хөтөлбөр, шийдвэр, тэмдэглэлүүдийг олон нийтэд мэдээлэх ажлыг цаг тухайд нь, тасралтгүй нийтэлж байх ёстой.

### **Санал өгөх технологи**

12. Сонгуулийн санал тоолох технологид итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн тулд төхөөрөмж, программ хангамжид хөндлөнгийн баталгаажуулалт, аудит хийх боломжийг хуульд тодорхой тусгах шаардлагатай.

### **Сонгогчийн бүртгэл**

13. Сонгогчдын нэрийн жагсаалтын ил тод байдал, сонгогчдын бүртгэлийн үнэн зөв байдалд итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн тулд Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар бүртгэлтэй холбоотой өгөгдлийг бүс бүсээр нь тоймлохоос илүүтэй, нутаг дэвгэрээр нь задлан ангилсан мэдээллийг нийтлэх эсэх талаар тунгаах нь зүйтэй.

### **Нэр дэвшигчийн бүртгэл**

14. Өмнө нь зөвлөмж гаргаж байсанчлан, хугацаа хэтэрсэн өр, татварын өр, ял шийтгүүлж байсан гэх үндэслэлээр эрхийг хязгаарласан заалтыг хүчингүй болгох ёстой. Нэр дэвших хүсэлтэй төрийн албан хаагч, нэр дэвшигчийг бүртгэлийн хугацаа эхлэх хүртэл албан тушаалаасаа чөлөөлөгдөх шаардлагагүй.
15. Улс төрийн олон ургалч байдалд шаардлагагүй хязгаарлалт тавилгүй, олон улсын жишигт нийцүүлэхийн тулд өрсөлдөгчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт бодлогод суурилсан шалгуур тавих нь зохимжгүй тул дахин тунгааж үзэх шаардлагатай.

### **Сонгуулийн кампанит ажил**

16. Сонгуулийн кампанит ажил зохион байгуулах эрх зүйн орчин хэт хязгаарласан байдлыг бууруулах, сонгуулийн албан ёсны сурталчилгааны хугацаа, түүнээс өмнөх цаг үед бүх



өрсөлдөгчид сурталчилгаа явуулах ижил тэгш нөхцөлөөр хангаж хуульд өөрчлөлт оруулах нь зүйтэй.

### Кампанит ажлын санхүүжилт

17. Үндэсний Аудитын газар хуулиар олгогдсон эрхээ бүрэн хэрэгжүүлж, орон нутагт буй салбар нэгжээрээ дамжуулан мэдээлэл цуглуулж, сонгуулийн кампанит ажлын санхүүжилт, зарцуулалтад үр дүнтэй мониторинг хийх ёстой.

### Хэвлэл мэдээлэл

18. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл олон нийтэд шүүмжлэлт өнгө аястай мэдээлэл хүргэхэд саад болох, сүрдүүлэх зорилготой шүүхийн нэхэмжлэлүүдтэй холбоотой асуудлаар олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхэд эрх бүхий байгууллагууд, сонгуулийн бусад оролцогч талууд анхаарч ажиллах нь зүйтэй.
19. Өрсөлдөгч нарын талаарх мэдээ, сурвалжилгын дамжуулах дээд хязгаарыг үгүй болгож хуульд өөрчлөлт оруулж болно. Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн сувгаар кампанит ажлын хөтөлбөр нь сонгогчдод олон талт, шинэлэг хэлбэрээр тэгш хүртээмжтэй хүрэхийн зэрэгцээ тэдэнд мэдээлэл хүргэхийг зорих ёстой.
20. Алагчлалгүй байх хуулийн шаардлагыг үр дүнтэй, цаг тухай нь хэрэгжүүлэхийн тулд ил тод арга зүй, хангалттай нөөц бүхий бие даасан этгээдэд хэвлэл мэдээллийн орчныг хянах, хэвлэл мэдээлэлтэй холбоотой гомдол шийдвэрлэх, зохицуулах үүргийг хариуцуулах талаар бодож үзэх хэрэгтэй.
21. Улс төрийн аль нэг хүчинд илүү үйлчлэхээс сэргийлж, алагчлаагүй, олон талт редакцын бодлогыг баримталж, үнэн зөв мэдээлэх зорилгоор олон нийтийн өргөн нэвтрүүлгийн сувгийн бие даасан байдлыг хүчирхэгжүүлэх тал дээр анхаарах шаардлагатай.

### Сонгууль ажиглалт

22. Иргэний ажиглагчдын бүлгүүд саадгүй нэвтрэх, зохион байгуулалтын хүндрэлийг багасгахын тулд сонгууль эрхэлсэн байгууллагууд ажиглагчид санал авах байр бүрээр бүртгүүлэх шаардлагыг цуцлах талаар бодож үзэх хэрэгтэй.

### Сонгуулийн өдөр

23. Цагдаагийн албан хаагч санал авах байрны дотор байхыг хязгаарлах, гагцхүү СХХ-ны ажилтны хүсэлтээр санал авах байр руу нэвтрэх зохицуулалтыг эргэцүүлж үзэх хэрэгтэй. Үгүйдээ л санал авах байранд цагдаагийн албан хаагчийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон ёс зүйн дүрэм боловсруулж, цагдаа албан үүргээ үр дүнтэйгээр, хөндлөнгийн оролцоогүйгээр гүйцэтгэх боломжийг олгох ёстой.
24. Ил тод байдлыг хангахын тулд СЕХ сонгуулийн урьдчилсан болон эцсийн үр дүнг санал авах байраар нь задлан харуулсан мэдээллийг нэн даруй цахим хуудаснаа нийтлэх ёстой. Сонгуулийн үр дүнг бодитоор нягтлахад нийтэлсэн үр дүн нь бүртгэгдсэн сонгогчдын тоо, нэр дэвшигч тус бүрийн авсан саналын тоо, хоосон саналын хуудас, нийт хүлээн авсан болон устгасан саналын хуудасны тоо зэрэг мэдээллийг агуулах ёстой.



## ХАВСРАЛТ I: СОНГУУЛИЙН ЭЦСИЙН ҮР ДҮН<sup>93</sup>

### Ирц

	Нийт	Хувь
Бүртгэгдсэн сонгогч	2,089,935	100%
Саналын хуудас / ирц	1,459,830	69.85%
Хүчинтэй саналын хуудас	1,455,188	99.68% (нийт өгсөн саналын)
Хоосон саналын хуудас	4,642	0.32% (нийт өгсөн саналын)

### МАЖОРИТАР ӨРСӨЛДӨӨН

Сонгогдсон нэр дэвшигч	Намын харьяалал	Авсан саналын тоо	Хувь
<b>1-р тойрог</b>			
Оюунсайханы Алтангэрэл	АН	66,656	52.2%
Сайнхүүгийн Ганбаатар	АН	61,824	48.4%
Батмөнхийн Батцэцэг	МАН	60,610	47.5%
Пүрэвбаатарын Мөнхтулга	АН	60,059	47.0%
Дашдондогийн Ганбат	АН	58,263	45.6%
Ганзоригийн Тэмүүлэн	МАН	58,228	45.6%
Ганбатын Хосбаяр	АН	56,612	44.3%
Дамдинсүрэнгийн Жаргалсайхан	АН	56,177	44.0%
Даваагийн Цогтбаатар	АН	55,935	43.8%
<b>2-р тойрог</b>			
Сандагийн Бямбацогт	МАН	79,826	56.6%
Одонгийн Цогтгэрэл	АН	75,927	53.8%
Дашзэгвийн Амарбаясгалан	МАН	74,199	52.6%
Бөхчулууны Пүрэвдорж	АН	74,152	52.6%
Баттогтохын Чойжилсүрэн	МАН	73,280	52.0%
Банзрагчийн Түвшин	АН	68,829	49.5%
Очирбатын Амгаланбаатар	АН	67,597	47.9%
Батжаргалын Заяабал	МАН	67,321	47.7%
Загджавын Мэндсайхан	МАН	66,594	47.2%
Энхбатын Болормаа	МАН	64,838	46.0%
<b>3-р тойрог</b>			
Хажекберийн Жангабыл	МАН	25,138	54.4%
Тилеуханы Аубакир	МАН	23,772	51.5%
Буланы Бейсен	АН	21,454	46.4%
<b>4-р тойрог</b>			
Халтмаагийн Баттулга	АН	60,933	47.4%
Лувсанцэрэнгийн Энх-Амгалан	МАН	50,728	46.4%

<sup>93</sup> СЕХ-ноос нийтэлсэн сонгуулийн эцсийн үр дүн.

Дамбын Батлут	МАН	58,657	45.6%
Бат-Өлзийн Бат-Эрдэнэ	МАН	53,474	41.6%
Доржсүрэнгийн Үүрийнтуяа	МАН	51,805	40.3%
Лхагвын Мөнхбаатар	МАН	49,182	38.2%
Жадамбын Бат-Эрдэнэ	МАН	48,198	37.5%
Цэрэнпилийн Даваасүрэн	МАН	47,557	37.0%
<b>5-р тойрог</b>			
Болдын Жавхлан	МАН	62,898	48.9%
Цэвэгдоржийн Туваан	АН	60,644	47.2%
Далайн Батбаяр	АН	53,903	41.9%
Жадамбын Энхбаяр	МАН	53,306	41.5%
Буяагийн Тулга	МАН	50,017	38.9%
Гонгорын Дамдинням	МАН	49,307	38.4%
Сүхбаатарын Эрдэнэболд	АН	47,892	37.3%
Сүрэнжавын Лүндэг	МАН	46,712	36.4%
Чинбатын Ундрэм	МАН	44,925	35.0%
Жигжидийн Батжаргал	МАН	44,775	34.8%
<b>6-р тойрог</b>			
Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ	МАН	55,469	56.4%
Мягмарсүрэнгийн Бадамсүрэн	МАН	46,667	47.5%
Цагаанхүүгийн Идэрбат	МАН	45,777	46.5%
Ухнаагийн Отгонбаяр	МАН	43,724	44.5%
Лхагвасүрэнгийн Соронзонболд	МАН	43,400	44.1%
Шинэбаярын Бямбасүрэн	АН	43,047	43.8%
Мөнгөнцогийн Ганхүлэг	МАН	42,248	43.0%
<b>7-р тойрог</b>			
Ренчинбямбын Сэддорж	АН	41,428	46.2%
Борхүүгийн Дэлгэрсайхан	МАН	39,331	43.8%
Нанзадын Наранбаатар	МАН	37,134	41.4%
Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан	АН	37,019	41.2%
Цагаанхүүгийн Мөнхбат	АН	36,433	40.6%
Равжихын Эрдэнэбүрэн	АН	36,379	40.3%
Гомбын Ганбаатар	АН	35,629	39.7%
<b>8-р тойрог</b>			
Жигжидсүрэнгийн Чинбүрэн	МАН	58,854	34.1%
Батгөмөрийн Энхбаяр	МАН	56,247	32.6%
Пүрэвсүрэнгийн Наранбаяр	ХҮН	53,358	30.9%
Энхтайваны Бат-амгалан	МАН	52,872	30.6%
Хүрэлбаатарын Булгантуяа	МАН	51,214	29.6%
<b>9-р тойрог</b>			
Жаргалсайханы Золжаргал	ХҮН	39,771	38.1%

Хассуурийн Ганхуяг	МАН	39,012	37.4%
Жамбалын Ганбаатар	МАН	28,414	27.2%
<b>10-р тойрог</b>			
Ням-Осорын Учрал	МАН	67,107	53.1%
Отгоншарын Батнайрамдал	МАН	43,261	34.2%
Цэндийн Баатархүү	АН	36,540	28.9%
Нацагдоржийн Батсүмбэрэл	МАН	34,261	27.1%
Дамдины Цогтбаатар	МАН	32,907	26.0%
Хөххүүгийн Болормаа	АН	32,279	25.6%
<b>11-р тойрог</b>			
Энхбаярын Батшугар	МАН	58,914	42.4%
Норовын Алтанхуяг	АН	53,659	38.6%
Наранцэцэгийн Алтаншагай	МАН	48,527	33.7%
Пүрэвжавын Сайнзориг	МАН	46,833	33.7%
Чинбатын Номин	МАН	44,187	31.8%
<b>12-р тойрог</b>			
Тогтмолын Мөнхсайхан	МАН	45,396	39.3%
Чулуунбилэгийн Лодойсамбуу	АН	40,937	35.5%
Жуковын Алдаржавхлан	МАН	40,915	35.4%
<b>13-р тойрог</b>			
Сайнбуянгийн Амарсайхан	МАН	16,539	52.5%
Цэндийн Сандаг-Очир	МАН	12,347	39.2%

### ПРОПОРЦИОНАЛЬ ӨРСӨЛДӨӨН

Нам/Эвсэл	Авсан санал	Хувь	Босго даваагүй нам, эвслээс хуваарилагдсан санал	Нийт санал	Суудал
МАН	509,482	35.01%	+41,577	551,059	18
АН	438,506	30.13%	+41,577	480,083	16
ХҮН нам	151,111	10.38%	+41,577	192,688	6
Үндэсний Эвсэл	75,196	5.17%	+41,577	116,773	4
Иргэний Зориг Ногоон нам	73,006	5.02%	+41,577	114,583	4

### НИЙТ СУУДАЛ

Нам/Эвсэл	Тойрог	Намын жагсаалт	Нийт
МАН	50	18	68
АН	26	16	42
ХҮН нам	2	6	8
Үндэсний Эвсэл	0	4	4
Иргэний Зориг Ногоон нам	0	4	4

## ХАВСРАЛТ II: ОЛОН УЛСЫН СОНГУУЛЬ АЖИГЛАХ ХОРООНД АЖИЛЛАСАН АЖИГЛАГЧДЫН ЖАГСААЛТ

### Европын Парламент

Tomáš	Zdechovský	Бүгд Найрамдах Чех Улс	Төлөөлөгчдийн тэргүүн
Marina	Graser Lasic	Хорват	ЕП-ын нарийн бичгийн дарга нарын газар
Jaak	Madison	Эстони	ЕП-ын гишүүн
Fabio Massimo	Castaldo	Итали	ЕП-ын гишүүн
Ignazio	Corrao	Итали	ЕП-ын гишүүн
Niccolò	Rinaldi	Итали	ЕП-ын нарийн бичгийн дарга нарын газар
Monia	Albertini	Итали	Төлөөлөгчдийн багийн гишүүн
Tessel Dian Joel	Giele	Netherlands	Төлөөлөгчдийн багийн гишүүн
Robert	Biedroń	Poland	ЕП-ын гишүүн
Ryszard	Czarnecki	Poland	ЕП-ын гишүүн
Anna	Kaczmarek	Poland	Төлөөлөгчдийн багийн гишүүн
Leopoldo	López Gil	Spain	ЕП-ын гишүүн
Gonzalo	De Mendoza	Spain	ЕП-ын нарийн бичгийн дарга нарын газар

### АИХЭГ САХ-ны Урт хугацааны ажиглагчид

Dhimiter	Gjodede	Албани
Susanne	Giendl	Австри
Miroslav	Brozman	Бүгд Найрамдах Чех Улс
Anne	Poulsen	Дани
Catherine	Iffly	Франц
Pascale	Le Hel	Франц
Natalie	Krieger	Герман
Thomas	Leszke	Герман
Suhail	Ahmad	Ирланд
Francesca	Calvi Giancristofaro	Итали
Aidos	Kenzhebayev	Казакстан
Agatha Maria Johanna	de Wit	Нидерланд
Andreas	Aabel	Норвег
Nicolay	Paus	Норвег
Andrey	Ostvald	Оросын Холбооны Улс
Aleksandr	Studenikin	Оросын Холбооны Улс
Ewa Helena Christina	Jacobsson	Швед
Astrid	Nunez	Швед

### АИХЭГ САХ-ны Богино хугацааны ажиглагчид

Dominik	Rastinger	Австри
Hannah Yolanda	Scheller	Австри
Heinrich	Hirsch	Австри
Lenka	Audy	Бүгд Найрамдах Чех Улс
Lucie	Štěpánková	Бүгд Найрамдах Чех Улс
Zaneta	Vencourova	Бүгд Найрамдах Чех Улс
Vardan	Khachatryan	Бүгд Найрамдах Чех Улс
Lukáš	Janeček	Бүгд Найрамдах Чех Улс
Klaus	Koenig	Дани
Astrid Viktoria	Torp-Pedersen	Дани
Lise	Thorsen	Дани
Inge	Jensen	Дани
Rosangela	de Jesus das Neves	Дани
Christian	Andersen	Дани
Hilda	Casier	Дани
Erik	Nielsen	Дани
Kahina	Hadid	Дани
Inger Marie	Vennize	Дани
Ivika	Enula	Эстони
Petteri	Londen	Финланд
Hanna	Vuokko	Финланд
Tommi	Jämsä	Финланд
Maria	Vaittinen	Финланд
Maria	Vaittnen	Финланд
Jasmine	Salhab	Франц
Sebastien	Peyrouse	Франц
Matthias	Clerc	Франц
Gael	Dupont-Ferrier	Франц
Jessica	Berthereau	Франц
Anais	Fiault	Франц
Julien	Paupert	Франц
Dominika	Eichstaedt	Герман
Pavel	Utitz	Герман
Magdalena	Metzler	Герман
Eva	Gmelin	Герман
Melanie	Breiter	Герман
Leonard	Pledl	Герман
Malte	Seebens	Герман
Johannes	Dopffel	Герман
Lisa	Becker	Герман
Gerda Elisabeth Charlotte	Dopheide	Герман
Lars	Gerold	Герман
Oliver	Fritz	Герман
Jakob	Preuss	Герман
Eckart	Rohde	Герман
Anca	Stan	Герман
Bartosz	Walenda	Герман
Karola Claudia	Machalett	Герман
Susanne	Theilmann	Герман
Annelie	Koschella	Герман

Maxim	Menschenin	Герман
Ulrike	Dässler	Герман
Tina	Mede-Karpenstein	Герман
Johanna	Berger	Герман
Arnim	Stauth	Герман
Rainer	Otter	Герман
Julia Marieke	Gellermann	Герман
Cornelia	Nauck	Герман
Werner	Klinger	Герман
Hans-Heinrich	Schneider	Герман
Udo	Weber	Герман
Péter	Gáspár	Унгар
Eilís	Ward	Ирланд
Ruth	Moralee	Ирланд
Michael	O'Shea	Ирланд
Terence	Duffy	Ирланд
Audrey	Ryan	Ирланд
Peter	Carroll	Ирланд
Anne	Marlborough	Ирланд
Diego	Lazzarich	Итали
Enrica	Brancaleoni	Итали
Federica	Raimondo	Итали
Wilhelmina	Theuws	Нидерланд
Anass	Bendrif	Нидерланд
Anne-Mischa	van Schouwenburg	Нидерланд
Laurens	Teule	Нидерланд
Mari	Hagen	Норвег
Børge Røssaak	Nilsen	Норвег
Nils Gunnar	Songstad	Норвег
Gro	Tjore	Норвег
Stefan	Hejnowicz	Польш
Alexandru Dan	Vasc	Румын
Claudia-Iolanda	Butnaru	Румын
Vitalii	Fadeev	Оросын Холбооны Улс
Aleksandr	Fediakov	Оросын Холбооны Улс
Andrei	Glushchenko	Оросын Холбооны Улс
Nadezhda	Obukhova	Оросын Холбооны Улс
Ekaterina	Chirkina	Оросын Холбооны Улс
Mariia	Toporikova	Оросын Холбооны Улс
Dmitrii	Iakimets	Оросын Холбооны Улс
Diana	Ainetdinova	Оросын Холбооны Улс
Aleksei	Sinegubov	Оросын Холбооны Улс
Mikhail	Zaitsev	Оросын Холбооны Улс
Inna	Tarysheva	Оросын Холбооны Улс
Anna	Kovalchuk	Оросын Холбооны Улс
Mariia	Astakhova	Оросын Холбооны Улс
Kristina	Bogdanova	Оросын Холбооны Улс
Vera	Duganova	Оросын Холбооны Улс
Denis	Podolskii	Оросын Холбооны Улс
Viktor	Evseev	Оросын Холбооны Улс
Ivan	Zavorin	Оросын Холбооны Улс

Anton	Postigov	Оросын Холбооны Улс
Elena	Balandina	Оросын Холбооны Улс
Konstantin	Pakhorukov	Оросын Холбооны Улс
Natalia	Minakova	Оросын Холбооны Улс
Iia	Baranov	Оросын Холбооны Улс
Anton	Revutskii	Оросын Холбооны Улс
Ekaterina	Gorbatova	Оросын Холбооны Улс
Valeriia	Bulva	Оросын Холбооны Улс
Alexander	Bedritskiy	Оросын Холбооны Улс
Alexander	Konkov	Оросын Холбооны Улс
Vsevolod	Perevozchikov	Оросын Холбооны Улс
Ivan	Fetisov	Оросын Холбооны Улс
Elena	Satiukova	Оросын Холбооны Улс
Mikhail	Stepykin	Оросын Холбооны Улс
Leili	Rustamova	Оросын Холбооны Улс
Arina	Androsova	Оросын Холбооны Улс
Egor	Baburin	Оросын Холбооны Улс
Andrei	Borodin	Оросын Холбооны Улс
Dmitrii	Makarov	Оросын Холбооны Улс
Alena	Konovalenko	Оросын Холбооны Улс
Anatoly	Ivanov	Оросын Холбооны Улс
Tatiana	Syatchikhina	Оросын Холбооны Улс
Iñaki	Garcia-Blanco	Испани
Olga	Martin Gonzalez	Испани
Klas Henrik Max	Kettnaker	Швед
Lisa	Westholm	Швед
Sofia Leila	Zitouni	Швед
Karl Johan Sebastian	Eklund	Швед
Anna Elisabeth	Enarsson	Швед
Helena Birgitta	Munther	Швед
Pär Olof Daniel	Olsson	Швед
Emma Kristina Sofia	Sandahl	Швед
Carolina	Hamma	Швед
Sophia Ingrid Amanda	Tuwesdotter	Швед
Alessandro	Bartolini	Швед
Hanna	Norell	Швед
Peter Mattias	Goldmann	Швед
Carl Fredrik Bertil	von Essen	Швед
Karin Susanna	Fält	Швед
Kristina Ingrid Sofia	Ulgemo	Швед
Gabriella	Ingerstad	Швед
André	Nilén	Швед
Bengt Jonas	Frykman	Швед
David	Dunsmore	Америкийн Нэгдсэн Улс
Degee	Wilhelm	Америкийн Нэгдсэн Улс
Melody	Shekari	Америкийн Нэгдсэн Улс
William	Baker	Америкийн Нэгдсэн Улс
Michael	Paarlberg	Америкийн Нэгдсэн Улс
Lori	Renee Cloutier	Америкийн Нэгдсэн Улс
John	Conard	Америкийн Нэгдсэн Улс
Murodilla	Alimbaev	Узбекстан





**АИХЭГ САХ-ны Үндсэн баг**

Jennifer	Brush	Америкийн Нэгдсэн Улс	Хорооны тэргүүн
Vania	Anguelova	Болгар	
Marianna	Skopa	Грек	
Julia	Manchin	Унгар	
Slaviša	Kotlaja	Монтенегро	
Robert	Lech	Польш	
Tomasz	Jańczy	Польш	
Michał	Ostańkiewicz	Польш	
Ranko	Vukčević	Серб	
Maja	Sandić	Серб	
Ivan	Godársky	Словак	
Andreas	Roth	Швед	
Farrukh	Juraqulov	Тажикистан	

## АИХЭГ-ЫН ТУХАЙ

Ардчилсан Институт, Хүний Эрхийн Газар нь ЕАБХАБ-ын үндсэн институт бөгөөд оролцогч улсуудад “хүний эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн хүндэтгэх, хууль дээдлэх ёсыг сахих, ардчиллын үндсэн зарчмыг сурталчлах, (...) ардчилсан институтуудыг хамгаалж, бэхжүүлэх, болон нийгэмд харилцан хүндэтгэлтэй хандах байдлыг хөхүүлэн дэмжих”-д туслалцаа үзүүлэх зорилготой (1992 оны Хельсинкийн Дээд хэмжээний уулзалтын баримт бичиг). Энэ нь ЕАБХАБ-ын хүний хэмжүүр гэж үздэг.

Варшавт (Польшийн) байрладаг АИХЭГ нь 1990 оны Парисын Дээд хэмжээний уулзалтын үеэр Чөлөөт сонгуулийн төлөө газар нэртэйгээр үүсгэн байгуулагдсан бөгөөд 1991 оны 5 дугаар сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Тус байгууллагын эрх, үүрэг нь өргөжсөнтэй холбоотой хүний эрх, ардчилал гэх үгсийг нэрд оруулж өөрчилсөн. Өнөөдрийн байдлаар 150 гаруй ажилтан ажиллаж байна.

АИХЭГ нь **сонгуулийн ажиглалт** хийх чиглэлээр Европт тэргүүлдэг байгууллага юм. ЕАБХАБ-ын бүс нутагт явагдаж байгаа сонгуулиуд ЕАБХАБ-ын үүрэг амлалт, ардчилсан сонгуулийн төлөөх олон улсын бусад хэм хэмжээ болон үндэсний хууль тогтоомжийг даган мөрдөж байгаа эсэхэд үнэлгээ өгөх олон мянган ажиглагчдыг томилох ажлыг жил бүр зохион байгуулдаг. Тус байгууллагын өвөрмөц аргачлал нь сонгуулийн үйл явцад бүрэн ажиглалт хийх боломж олгодог. АИХЭГ нь туслалцааны төслөөр дамжуулан гишүүн орнуудынхаа сонгуулийн хууль эрх зүйн тогтолцоог сайжруулахад тусалдаг.

АИХЭГ-ын **ардчиллын** үйл ажиллагаанд хууль дээдлэх ёс, хууль эрх зүйн дэмжлэг, ардчилсан засаглал, шилжилт хөдөлгөөн, шилжин суух эрх чөлөө, жендэрийн тэгш байдал багтана. АИХЭГ нь ардчилсан бүтцийг хөгжүүлэхийг эрэлхийлэн, жил бүр тусламжийн зорилтот хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг.

АИХЭГ нь түүнчлэн гишүүн орнууддаа ЕАБХАБ-ын хүний эрх, ардчилалтай холбоотой цогц хэм хэмжээ, үйл ажиллагааны үүрэг амлалтын дагуу **хүний эрх**, үндсэн эрх чөлөөг хөхүүлэн дэмжих, хамгаалах үүргээ биелүүлэхэд нь тусалдаг. Ингэхийн тулд хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, тухайлсан буюу сэдэвчилсэн чиглэлээр, үүний дотор терроризмтой тэмцэх явцад хөндөгдөх хүний эрх, хүний наймааны гэмт хэргийн хохирогчдын эрхийн хамгаалалтыг нэмэгдүүлэх, хүний эрхийн боловсрол, сургалт, хүний эрхийн мониторинг хийж, тайлан гаргах болон эмэгтэйчүүдийн эрх, аюулгүй байдлын талаарх чадавхыг бэхжүүлэх, мэдлэг туршлагаа хуваалцах чиглэлээр янз бүрийн түншүүдтэй хамтран ажилласны дүнд амжилттай ажиллаж байна.

АИХЭГ нь бусдад **хүндэтгэлтэй хандах, үл ялгаварлан гадуурхах** чиглэлийн хүрээнд бусдыг үзэн ядах гэмт хэрэг, арьсны үзлийн зөрчил, гадаад иргэдийг үзэн ядах үзэл, семитийн эсрэг үзэл болон бусад хэлбэрийн үл хүндэтгэсэн үйлдэлд хариу арга хэмжээ авах чадварыг бэхжүүлэхэд гишүүн орнууддаа тусалдаг. АИХЭГ-ын бусдад хүндэтгэлтэй хандах, үл ялгаварлан гадуурхахтай холбоотой үйл ажиллагаа нь дараах асуудалд чиглэнэ. Үүнд, хууль тогтоомж; хууль биелүүлэх тухай сургалт; үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх арга хэмжээг хянах, тайлагнах, нягтлах; түүнчлэн бусдад хүндэтгэлтэй хандах, хүндэтгэх болон хамтын ойлголцлыг хөхүүлэн дэмжсэн боловсролын арга хэмжээ эзрэг багтана.

ЕАБХАБ-ын АИХЭГ нь гишүүн орнуудынхаа **Ром болон Синтичууд** (Roma and Sinti) талаар баримтлах бодлогод нь зөвлөгөө өгдөг. Мөн тэднийг чадавхжуулах, сүлжээ үүсгэх асуудлыг хөхүүлэн дэмжихийн зэрэгцээ бодлого боловсруулах түвшинд тэдний төлөөллийг оролцуулахыг дэмждэг.

АИХЭГ-ын бүх үйл ажиллагааг ЕАБХАБ-ын гишүүн орнууд, ЕАБХАБ-ын институтууд, түүнчлэн олон улсын бусад байгууллагуудын нягт хамтын ажиллагаа, уялдаатайгаар хэрэгжүүлдэг.

Дэлгэрэнгүй мэдээллийг АИХЭГ-ын [www.osce.org/odihr](http://www.osce.org/odihr) цахим хуудаснаас үзнэ үү.